


# СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙГ ХЭРХЭН АВАХ ВЭ?



 Цахимаар:

[www.1212.mn](http://www.1212.mn)

Статистик мэдээллийн  
нэгдсэн сан



[www.nso.mn](http://www.nso.mn)

Та статистик мэдээллийг байнга  
авч байхыг хүсвэл **ЭНД ДАРЖ**  
бүртгүүлнэ үү

Энэ хэсэгт өөрийн e-mail  
хаягаа бүртгүүлснээр  
статистикийн мэдээллийг  
цаг алдалгүй тогтмол авч  
байх болно.

**SOCIAL NETWORK**



[www.facebook.com/  
Статистик-Мэдээлэл](http://www.facebook.com/Статистик-Мэдээлэл)



[www.twitter.com/  
statistic\\_mn](http://www.twitter.com/statistic_mn)



Ухаалаг гар утас, таблет  
ашиглан статистик мэдээлэл  
авах **ezStat** аппликейшн



Статистикийн хэвлэмэл  
бүтээгдэхүүнийг унших  
**Монстат** аппликейшн



**Утсаар:**



Лавлах утас

**1900-1212**



**МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО**

**МОНГОЛ УЛСЫН НИЙГЭМ,  
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ**

**1 сар  
2017**

Улаанбаатар хот

---

---

## ГАРЧИГ

Ерөнхий тэмдэглэл .....	3
Товч танилцуулга .....	4
Дэлхийн эдийн засаг, гадаад зах зээлийн тойм .....	30
Үндсэн үзүүлэлтүүд .....	33
I. Хөдөлмөр .....	34
II. Өрхийн орлого, зарлага .....	46
III. Нийгмийн даатгал, халамж .....	52
IV. Эрүүл мэнд .....	54
V. Цаг уур, агаарын бохирдол .....	61
VI. Гэмт хэрэг .....	68
VII. Дотоодын нийт бүтээгдэхүүн .....	72
VIII. Мөнгө, зээл, үнэт цаасны зах зээл .....	78
IX. Улсын нэгдсэн төсөв .....	85
X. Гадаад худалдаа .....	88
XI. Үнэ .....	101
XII. Хөдөө аж ахуй .....	121
XIII. Аж үйлдвэр .....	123
XIV. Дотоод худалдаа .....	131
XV. Тээвэр .....	133
XVI. Нийтийн хоол, зочид буудал .....	135
Хавсралт .....	140
Аргачлалын тайлбар .....	153

### I. Саруудыг ром тоогоор тэмдэглэв

(I, II, III, IV, V... г.м)

Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдэх дүнг харуулахдаа I-IV, I-XI зэргээр илэрхийлэв.

### II. Дараах тэмдэглэлийг ашиглав:

- ... мэдээлэл байхгүй
- 0.0 маш бага тоо
- гүйцэтгэл байхгүй.

“Үүнээс” гэдгийг харуулах бөгөөд зарим тохиолдолд тухайн үзүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийн нийлбэр нэгдсэн дүнтэй тэнцэхгүй байж болно.

III. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрүүтэй байж болно.



IV. Та цахим хэлбэрээр үзэж буй тохиолдолд тухайн салбарын логог дарж дэлгэрэнгүй мэдээллийг хүснэгтээр excel хэлбэрээр татан авах боломжтой /жич: интернетэд холбогдсон байх ёстой/



V. Та өөрийн гар утаснаас QR code уншуулагч апп ашиглан тухайн салбарын дэлгэрэнгүй мэдээллийг excel хэлбэрээр татан авч үзэх боломжтой /жич: интернетэд холбогдсон байх ёстой/

Монгол Улсын нийгэм,  
эдийн засгийн байдал  
(2017 оны 1 дүгээр сарын байдлаар)

I. НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ




I.1 Бүртгэлтэй ажилгүй иргэн

Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад ажил хайж бүртгүүлсэн иргэд 2017 оны 1 дүгээр сарын эцэст 47.3 мянга болж, 34.3 (72.5%) мянга нь бүртгэлтэй ажилгүй иргэд, 13.0 (27.5%) мянга нь ажилтай боловч өөр ажил хайж байгаа иргэд байна.

Нийт бүртгэлтэй ажилгүй иргэд нь өмнөх оны мөн үеэс 348 (1.0%) хүнээр, өмнөх сараас 160 (0.5%) хүнээр буурч 34.3 мянга болж, 17.8 (52.0%) мянга нь эмэгтэйчүүд байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 11.8 (34.5%) мянга нь Улаанбаатарт, 7.7 (22.4%) мянга нь Хангайн бүсэд, 6.3 (18.3%) мянга нь Төвийн бүсэд, 5.6 (16.4%) мянга нь Баруун бүсэд, 2.9 (8.4%) мянга нь Зүүн бүсэд байна.

Аймаг, нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад 2017 оны 1 дүгээр сард ажилгүй 7.6 мянган иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй байсан 746 иргэн ажилд зуучлагдан орж, 7.1 мянган иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан байна. Эдгээр үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад шинээр бүртгүүлсэн ажилгүй иргэд 1.2 (13.8%) мянган хүнээр, ажилд зуучлагдан орсон иргэд 237 (24.1%) хүнээр буурч, харин ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан иргэд 988 (16.3%) хүнээр өсчээ.

Зураг I.1 Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад шинээр бүртгүүлсэн, ажилд зуучлагдан орсон иргэд, сараар




Эх үүсвэр: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны сар бүрийн мэдээлэл

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 45.1 хувийг бүрэн дунд, 30.8 хувийг дипломын дээд болон бакалаврын, 7.0 хувийг техникийн болон мэргэжлийн, 6.3 хувийг суурь, 5.6 хувийг тусгай мэргэжлийн дунд, 2.3 хувийг бага, 1.8 хувийг магистр, доктор, 1.1 хувийг боловсролгүй иргэд эзэлж байна.

Улсын хэмжээнд бүртгэлтэй ажилгүй иргэдийн 57.2 хувийг 15-34 насны залуучууд эзэлж, энэ үзүүлэлт Увс, Баянхонгор, Өвөрхангай, Говь-Алтай, Дундговь, Архангай, Дорноговь, Дорнод, Төв, Орхон, Ховд, Сэлэнгэ, Сүхбаатар, Өмнөговь аймагт улсын дунджаас 1.0-12.3 пунктээр илүү байна.

Зураг 1.2 Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшнээр, 2017 оны 1 дүгээр сарын эцэст, дүнд эзлэх хувиар



Эх үүсвэр: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны сар бүрийн мэдээлэл

## 1.2 Хүн амын эдийн засгийн идэвх

Ажиллах хүчний судалгааны 2016 оны 4 дүгээр улирлын дүнгээр улсын хэмжээнд ажиллах хүч буюу 15, түүнээс дээш насны эдийн засгийн идэвхтэй хүн ам 1239.8 мянга болж, 659.7 (53.2%) мянга нь эрэгтэй, 580.1 (46.8%) мянга нь эмэгтэйчүүд байна.

Эдийн засгийн идэвхтэй хүн амын 698.9 (56.4%) мянга нь хот, суурин газарт, 540.9 (43.6%) мянга нь хөдөө орон нутагт амьдарч байна.

Ажиллах хүчний оролцооны түвшин (АХОТ) 2016 оны 4 дүгээр улиралд улсын хэмжээнд 60.4 хувь, хотод 52.9 хувь, хөдөөд 73.7 хувь байна.

Ажиллах хүчний оролцооны түвшин 2016 оны 4 дүгээр улиралд өмнөх улирлаас 1.2 пунктээр, өмнөх оны мөн үеэс 0.1 пунктээр буурсан байна.

Хүснэгт 1.1. 15, түүнээс дээш насны хүн амын хөдөлмөр эрхлэлтийн байдал, улирлаар

Үзүүлэлт	2013 X-XII	2014 X-XII	2015		2016	
			VII-IX	X-XII	VII-IX	X-XII
<b>мянган хүн</b>						
Эдийн засгийн идэвхтэй хүн ам	1 125.4	1 127.7	1 195.4	1 164.1	1 263.2	1 239.8
Эрэгтэй	598.4	604.2	628.7	624.6	681.4	659.7
Эмэгтэй	527.0	523.5	566.7	539.5	581.8	580.1
Ажиллагчид	1 038.2	1 040.7	1 119.7	1 067.6	1 144.4	1 132.8
Ажилгүй иргэд	87.2	87.0	75.7	96.5	118.8	107.0
Эдийн засгийн идэвхгүй хүн ам	721.4	742.5	750.8	761.5	786.0	814.1
Эрэгтэй	290.1	285.1	296.2	306.6	321.8	325.6
Эмэгтэй	431.3	457.4	454.6	454.9	464.2	488.5
<b>хувь</b>						
Ажиллах хүчний оролцооны түвшин	60.9	60.3	61.4	60.5	61.6	60.4
Эрэгтэй	67.4	67.9	68.0	67.1	67.9	67.0
Эмэгтэй	55.0	53.4	55.5	54.3	55.6	54.3

Ажиллагчид өмнөх оны мөн үеэс 65.2 (6.1%) мянгаар, ажилгүй иргэд 10.5 (10.9%) мянгаар, эдийн засгийн идэвхгүй хүн ам 52.6 (6.9%) мянгаар өссөн байна.

15, түүнээс дээш насны нийт хүн амын 814.1 (39.6%) мянга нь эдийн засгийн идэвхгүй хүн ам бөгөөд тэдний 40.0 хувь нь эрэгтэйчүүд, 60.0 хувь нь эмэгтэйчүүд байна.

Эдийн засгийн идэвхгүй нийт хүн амын 257.6 (31.6%) мянга нь тэтгэврийнхэн болон өндөр настан, 223.5 (27.5%) мянга нь суралцагчид, 99.9 (12.3%) мянга нь хүүхэд асарсан, 72.4 (8.9%) мянга нь гэрийн ажилтай, 59.8 (7.3%) мянга нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд байна.

## Хүснэгт 1.2 15, түүнээс дээш насны хүн амын ажилгүйдэл, улирлаар

Үзүүлэлт	2013 X-XII	2014 X-XII	2015		2016	
			VII-IX	X-XII	VII-IX	X-XII
<b>мянган хүн</b>						
Ажилгүй иргэд	87.2	87.0	75.7	96.5	118.8	107.0
Эрэгтэй	46.5	49.1	39.4	56.4	72.7	67.0
Эмэгтэй	40.7	37.9	36.3	40.1	46.1	40.0
<b>хувь</b>						
Ажилгүйдлийн түвшин	7.8	7.7	6.3	8.3	9.4	8.6
Эрэгтэй	7.8	8.1	6.3	9.0	10.7	10.2
Эмэгтэй	7.7	7.2	6.4	7.4	7.9	6.9
хот	8.0	8.6	6.9	9.8	11.3	10.4
хөдөө	7.4	6.5	5.6	6.3	6.6	6.3



Судалгааны дүнгээр 2016 оны 4 дүгээр улиралд улсын хэмжээнд ажилгүй иргэд 107.0 мянга болж, 67.0 (62.6%) мянга нь эрэгтэйчүүд, 40.0 (37.4%) мянга нь эмэгтэйчүүд байна. Улсын хэмжээнд ажилгүйдлийн түвшин 2016 оны 4 дүгээр улиралд 8.6 хувь болж, өмнөх оны мөн үеэс 0.3 пунктээр өсч, өмнөх улирлаас 0.8 пунктээр буурсан байна.



## 1.3 Өрхийн орлого, зарлага

Өрхийн нийгэм, эдийн засгийн 2016 оны 4 дүгээр улирлын судалгаагаар нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлого 841.8 мянган төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 7.0 (0.8%) мянган төгрөгөөр буурлаа. Нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлого буурахад тэтгэвэр, тэтгэмжийн орлого 15.2 (9.2%) мянган төгрөг, бусад орлого 5.2 (7.0%) мянган төгрөгөөр өссөн хэдий ч хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн орлого 19.9 (24.6%) мянган төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлжээ.

## Хүснэгт 1.3 Нэг өрхийн сарын дундаж орлого, жил бүрийн 3, 4 дүгээр улирлаар

Орлогын төрөл	2015		2016		2016 X-XII 2015 X-XII
	VII-IX	X-XII	VII-IX	X-XII	
	төгрөг				хувь
Орлого - Бүгд	1 050 777	936 133	937 053	914 900	97.7
1. Мөнгөн орлого - Бүгд	937 675	848 842	853 279	841 844	99.2
Цалин хөлс	507 567	461 323	479 549	454 247	98.5
Тэтгэвэр, тэтгэмж	168 100	164 324	165 373	179 480	109.2
Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн орлого	100 243	80 984	62 556	61 052	75.4
Хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, үйлчилгээний орлого	72 897	68 246	67 878	67 949	99.6
Бусад орлого	88 868	73 965	77 923	79 116	107.0
2. Бусдаас үнэгүй авсан хүнсний болон хүнсний бус бүтээгдэхүүн	55 310	47 155	45 198	40 037	84.9
3. Өөрийн хувийн аж ахуйгаас хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүн	57 792	40 136	38 576	33 019	82.3

Нэг өрхийн сарын дундаж бодит (үнийн нөлөөллийг арилган тооцсон) мөнгөн орлогын хэмжээ 2016 оны 4 дүгээр улиралд 832.7 мянган төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 16.2 (1.9%) мянган төгрөгөөр буурлаа.

Нэг өрхийн сарын дундаж мөнгөн зарлага 2016 оны 4 дүгээр улиралд 898.0 мянган төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 39.4 (4.6%) мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Нэг өрхийн сарын дундаж мөнгөн зарлага нэмэгдэхэд хүнсний бус бараа, үйлчилгээний болон бусад зарлага 43.0 (6.9%) мянган төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ.



## Хүснэгт 1.4 Нэг өрхийн сарын дундаж зарлага, жил бүрийн 3, 4 дүгээр улирлаар

Зарлагын төрөл	2015		2016		2016 X-XII
	VII-IX	X-XII	VII-IX	X-XII	2015 X-XII
	төгрөг				хувь
Зарлага - Бүгд	1 049 666	945 886	1 009 928	971 084	102.7
1. Мөнгөн зарлага - Бүгд	936 564	858 595	926 154	898 028	104.6
Хүнсний бүтээгдэхүүний зарлага	237 051	208 777	213 839	205 789	98.6
Үүнээс:					
Мах, махан бүтээгдэхүүн	66 304	52 308	63 647	53 748	102.8
Гурил, гурилан бүтээгдэхүүн	60 304	59 049	56 011	58 145	98.5
Хүнсний бус бараа, үйлчилгээний болон бусад зарлага	676 513	628 309	693 314	671 357	106.9
Үүнээс:					
Тээвэр	70 189	65 379	59 577	58 813	90.0
Холбоо	34 944	34 195	31 990	31 700	92.7
Бусдад өгсөн бэлэг, тусламж	23 000	21 509	19 001	20 882	97.1
2. Бусдаас үнэгүй авсан хүнсний болон хүнсний бус бүтээгдэхүүн	55 310	47 155	45 198	40 037	84.9
3. Өөрийн хувийн аж ахуйгаас хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүн	57 792	40 136	38 576	33 019	82.3

Нэг өрхийн сарын дундаж бодит (үнийн нөлөөллийг арилган тооцсон) мөнгөн зарлагын хэмжээ 2016 оны 4 дүгээр улиралд 888.3 мянган төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 29.7 (3.5%) мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Өрхүүдийг мөнгөн орлого, зарлагаар нь бүлэглэн авч үзвэл, 2016 оны 4 дүгээр улиралд 300.0 мянган төгрөгөөс доош орлоготой өрх 120.0 (13.8%) мянга, мөн энэ хэмжээний зарлагатай өрх 96.6 (11.1%) мянга, 300.0-500.0 мянган төгрөгийн орлоготой өрх 154.8 (17.8%) мянга, мөн энэ хэмжээний зарлагатай өрх 158.3 (18.2%) мянга, 500.0-900.0 мянган төгрөгийн орлоготой өрх 297.5 (34.2%) мянга, мөн энэ хэмжээний зарлагатай өрх 292.2 (33.6%) мянга байна. Харин 2100.0 мянган төгрөгөөс дээш орлоготой өрх 33.9 (3.9%) мянга, мөн энэ хэмжээний зарлагатай өрх 42.6 (4.9%) мянга байна.

## Хүснэгт 1.5 Өрхийн бүлэглэлт, мөнгөн орлогоор, жил бүрийн 3, 4 дүгээр улирлаар

Бүлэг	2015				2016			
	VII-IX		X-XII		VII-IX		X-XII	
	Өрхийн тоо /мянган өрх/	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо /мянган өрх/	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо /мянган өрх/	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо /мянган өрх/	Дүнд эзлэх хувь
300 001 төгрөг хүртэл	101.3	12.3	135.7	15.8	124.0	14.4	120.0	13.8
300 001 - 500 000	142.4	17.3	155.5	18.1	153.3	17.8	154.8	17.8
500 001 - 700 000	130.1	15.8	153.8	17.9	155.0	18.0	173.1	19.9
700 001 - 900 000	118.6	14.4	120.3	14.0	118.0	13.7	124.4	14.3
900 001 - 1 100 000	95.5	11.6	84.2	9.8	94.8	11.0	95.7	11.0
1 100 001 - 1 600 000	126.8	15.4	127.2	14.8	134.4	15.6	125.3	14.4
1 600 001 - 2 100 000	61.8	7.5	45.5	5.3	50.0	5.8	42.6	4.9
2 100 001 төгрөгөөс дээш	46.9	5.7	36.9	4.3	31.9	3.7	33.9	3.9

## Хүснэгт 1.6 Өрхийн бүлэглэлт, мөнгөн зарлагаар, жил бүрийн 3, 4 дүгээр улирлаар

Бүлэг	2015				2016			
	VII-IX		X-XII		VII-IX		X-XII	
	Өрхийн тоо /мянган өрх/	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо /мянган өрх/	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо /мянган өрх/	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо /мянган өрх/	Дүнд эзлэх хувь
300 001 төгрөг хүртэл	80.7	9.8	96.2	11.2	79.2	9.2	96.6	11.1
300 001 - 500 000	137.5	16.7	168.4	19.6	143.9	16.7	158.3	18.2
500 001 - 700 000	142.5	17.3	160.7	18.7	153.3	17.8	148.7	17.1
700 001 - 900 000	130.9	15.9	130.6	15.2	132.7	15.4	143.5	16.5
900 001 - 1 100 000	94.7	11.5	92.8	10.8	102.5	11.9	98.3	11.3
1 100 001 - 1 600 000	134.2	16.3	122.8	14.3	149.9	17.4	134.0	15.4
1 600 001 - 2 100 000	56.0	6.8	52.4	6.1	57.7	6.7	47.8	5.5
2 100 001 төгрөгөөс дээш	46.9	5.7	35.2	4.1	42.2	4.9	42.6	4.9

## 1.4 Хүн амын амьжиргааны байдал

Нэг хүнд ногдох сарын дундаж бодит (үнийн нөлөөллийг арилган тооцсон) мөнгөн орлогын хэмжээ амьжиргааны доод түвшинтэй харьцуулахад улсын дунджаар 50.2 хувь, Төвийн бүсэд 67.6 хувь, Улаанбаатар хотод 60.4 хувь, Хангайн бүсэд 35.2 хувь, Баруун бүсэд 30.9 хувь, Зүүн бүсэд 26.3 хувиар өндөр байна.

Хүснэгт 1.7 Нэг хүнд ногдох сарын дундаж бодит мөнгөн орлого, амьжиргааны доод түвшний харьцаа, бүсээр

	Хүн амын амьжиргааны доод түвшин (2016 оны 2 дугаар сарын 8-наас мөрдсөн), төгрөг	Нэг хүнд ногдох сарын дундаж бодит (үнийн нөлөөллийг арилган тооцсон) мөнгөн орлого, 2016 оны 4 дүгээр улиралд, төгрөг	Бодит мөнгөн орлого Амьжиргааны доод түвшин %
Улсын дундаж	174 202	261 722	150.2
Баруун	164 800	215 678	130.9
Хангай	170 800	230 991	135.2
Төв	163 000	273 204	167.6
Зүүн	163 700	206 778	126.3
Улаанбаатар	183 700	294 622	160.4

Хүн амын хэрэглээний тэгш бус байдлыг тодорхойлох Жини коэффициент 2016 оны 4 дүгээр улиралд Төвийн бүсэд 0.359 болж, улсын дунджаас 0.01 нэгжээр их, Хангайн бүсэд 0.327, Баруун бүсэд 0.339, Улаанбаатар хотод 0.345, Зүүн бүсэд 0.347 болж, улсын дунджаас 0.002-0.022 нэгжээр бага байна. Жини коэффициент өмнөх оны мөн үеэс 0.019 нэгжээр, өмнөх улирлаас 0.031 нэгжээр их байна.

Хүснэгт 1.8 Тэгш бус байдлын хэмжигдэхүүн, бүсээр, жил бүрийн 3, 4 дүгээр улирлын байдлаар

	Жини коэффициент				Тейлийн индекс			
	2015		2016		2015		2016	
	VII-IX	X-XII	VII-IX	X-XII	VII-IX	X-XII	VII-IX	X-XII
Улсын дундаж	0.333	0.330	0.318	0.349	0.202	0.190	0.171	0.229
Баруун	0.295	0.330	0.294	0.339	0.145	0.189	0.142	0.212
Хангай	0.338	0.320	0.298	0.327	0.214	0.170	0.153	0.188
Төв	0.294	0.335	0.350	0.359	0.153	0.188	0.205	0.227
Зүүн	0.339	0.317	0.311	0.347	0.196	0.166	0.158	0.207
Улаанбаатар	0.341	0.324	0.306	0.345	0.218	0.192	0.159	0.240

Орлогын ялгаатай бүлэг доторх болон бүлэг хоорондох тэгш бус байдлыг харуулах Тейлийн индекс 2016 оны 4 дүгээр улиралд 0.229 болж, өмнөх оны мөн үеэс 0.039 нэгжээр, өмнөх улирлаас 0.058 нэгжээр их байна.

Хүснэгт 1.9 Хүн амын хэрэглээний бүтэц, хүн амын тооны тэнцүү 5 бүлгээр, дүнд эзлэх хувиар, бүсээр, 2016 оны 4 дүгээр улирлын байдлаар

	Нийт хэрэглээ	5 бүлэг				
		I (Хамгийн ядуу)	II	III	IV	V (Чинээлэг)
Улсын дундаж	100.0	7.6	11.9	16.1	22.3	42.1
Баруун	100.0	7.6	12.0	16.3	22.8	41.3
Хангай	100.0	7.9	12.2	16.4	22.8	40.7
Төв	100.0	6.7	11.5	16.4	22.5	42.9
Зүүн	100.0	7.4	11.3	16.3	23.0	42.0
Улаанбаатар	100.0	7.8	12.0	15.8	21.8	42.6



Улсын хэмжээнд 2016 оны 4 дүгээр улиралд хамгийн ядуу бүлгийн хүн амын хэрэглээ нийт хэрэглээнд 7.6 хувийг, хамгийн чинээлэг бүлгийн хүн амын хэрэглээ 42.1 хувийг эзэлж байна. Энэ нь хүн амын хамгийн чинээлэг 20 хувийнхны хэрэглээний дундаж хэмжээ хамгийн ядуу 20 хувийнхнаас 5.5 дахин их байгааг харуулж байна.



### 1.5 Нийгмийн даатгал, халамж

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын мэдээллээр нийгмийн даатгалын сангийн орлого 2017 оны 1 дүгээр сард 136.2 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 26.7 (24.4%) тэрбум төгрөгөөр өсч, зарлага 135.6 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 4.7 (3.4%) тэрбум төгрөгөөр буурчээ.

Нийгмийн даатгалын сангийн орлого 2017 оны 1 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 26.7 тэрбум төгрөгөөр нэмэгдэхэд тэтгэврийн даатгалын сангийн орлого 25.9 (34.4%) тэрбум төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 3.4 (27.0%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Зураг 1.3 Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, сараар



Нийгмийн даатгалын сангийн зарлага 2017 оны 1 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 4.7 тэрбум төгрөгөөр буурахад үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангийн зарлага 8.2 (73.4%) тэрбум төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлөв.

Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газрын мэдээллээр нийгмийн халамжийн сангаас 2017 оны 1 дүгээр сард 131.2 мянган хүнд 10.3 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгосон нь өмнөх оны мөн үеэс нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж авагчид 16.8 (11.4%) мянгаар, олгосон тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ 46.7 (0.4%) сая төгрөгөөр буурчээ. Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2017 оны 1 дүгээр сард 41.7 мянган хүн хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 6.2 (12.9%) мянгаар, олгосон тэтгэврийн хэмжээ 98.5 (1.6%) сая төгрөгөөр буурсан байна.

Нийгмийн халамжийн үйлчилгээ, хөнгөлөлтөд 2017 оны 1 дүгээр сард 24.2 мянган хүн хамрагдсаны 57.0 хувь нь нийгмийн халамжийн хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламжид хамрагдсан иргэд, 20.7 хувь нь ахмад настан, 16.4 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд, 5.2 хувь нь алдар цолтой ахмад



настай иргэд, 0.7 хувь нь нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдсан иргэд байна. Нийгмийн халамжийн үйлчилгээ болон хөнгөлөлтөд 2.7 тэрбум төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеэс 309.3 (10.4%) сая төгрөгөөр буурчээ.


Энэ оны 1 дүгээр сард 18 хүртэлх насны 621.0 мянган хүүхдэд 12.4 тэрбум төгрөгийг хүүхдийн мөнгөн тэтгэмжинд олгожээ.



### 1.6 Эрүүл мэнд


Улсын хэмжээнд 2017 оны 1 дүгээр сард 5464 эх амаржиж, амьд төрсөн хүүхэд 5502 болж, өмнөх оны мөн үеэс амаржсан эх 811 (12.9%)-ээр, амьд төрсөн хүүхэд 802 (12.7%)-оор буурсан байна.

Зураг 1.4 Амьд төрөлт, сараар, мянган хүн



Улсын хэмжээгээр нялхсын эндэгдэл 2017 оны 1 дүгээр сард 94 болж, өмнөх оны мөн үеэс 27 (22.3%)-оор, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 113 болж, 27 (19.3%)-оор буурсан байна.

Зураг I.5 1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдлийн түвшин, сараар




1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдэл 2017 оны 1 дүгээр сард 17 болж, өмнөх оны мөн үеэс 2 (11%)-оор, тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 21 болж, өмнөх оны мөн үеэс 1 (7.5%)-ээр буурсан байна.

Эхийн эндэгдэл 2017 оны 1 дүгээр сард 1 гарч, өмнөх оны мөн үеэс 2 (66.7%)-оор, мөн өмнөх сараас 5 (83.3%)-аар буурсан байна.


100 000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдэл 2017 оны 1 дүгээр сард 18.2, болж өмнөх оны мөн үеэс 29.4 (61.8%)-өөр буурчээ.

Зураг I.6 100 000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдлийн түвшин, сараар



Халдварт өвчнөөр өвчлөгчид 2017 оны 1 дүгээр сард 3558 болж, өмнөх оны мөн үеэс 2350 (39.8%)-иар буурахад улаанбурханаар өвчлөгчид 2721 (99.9%)-ээр, гар, хөл, амны өвчнөөр өвчлөгчид 99 (58.2%)-өөр, вирүст гепатитаар өвчлөгчид 18 (31.6%)-аар буурсан нь голлон нөлөөлсөн байна. Харин мөөгөнцрөөр өвчлөгчид 62 (52.5%)-оор, салхин цэцгээр өвчлөгчид 261(32.1%)-ээр, трихомониазаар өвчлөгчид 73 (16.7%)-аар, гонококкт халдвараар өвчлөгчид 40(9.6%)-өөр, тэмбүүгээр өвчлөгчид 38 (7.2%)-аар, сүрьеэгээр өвчлөгчид 22 (7.8%)-оор өссөн байна.

Зураг 1.7 Халдварт өвчнөөр өвчлөгчид, сараар, мянган хүн



Улаанбаатар хотод 2017 оны 1 дүгээр сард ХДХВ/ДОХ-ын 2 тохиолдол илэрч, улсын хэмжээнд бүртгэгдсэн ХДХВ/ДОХ-ын нийт тохиолдол 227 болсон байна.




## I.6 Байгаль орчин

### Цаг уур, агаарын бохирдол


Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн мэдээгээр 2017 оны 1 дүгээр сард хамгийн их хур тунадасны нийлбэр Увс аймгийн Баруунтуруун суманд 6.0 мм-т хүрсэн байна. Агаарын үнэмлэхүй их температур Өмнөговь аймгийн Ханбогд суманд 8.0 хэм, үнэмлэхүй бага температур Завхан аймгийн Баянтэс сум, Увс аймгийн Тэс суманд -45.0 хэмд хүрлээ. Салхины үнэмлэхүй их хурд Дорнод аймгийн Матад сумын нутгаар түр зуур 21 м/с хүрсэн байна.

Чанарын стандарт дахь хүлцэх агууламжаас азотын давхар ислийн хоногийн дундаж хүлцэх агууламж 2017 оны 1 дүгээр сард Улаанбаатар хотын Баруун 4 зам орчимд 31 удаа, Телевиз орчимд 28 удаа, Хархорин орчимд 23 удаа, Зуун айл болон Амгалангийн эцэс орчимд 20 удаа, Толгойт орчимд 18 удаа, 13-р хороолол орчимд 16 удаа, Ургах наран хороолол орчимд 15 удаа, Дамбадаржаа орчимд 11 удаа, Физик техникийн хүрээлэн орчимд 9 удаа, 1-р хороолол болон Хайлааст орчимд 6 удаа, хүхэрлэг хийн хоногийн дундаж хүлцэх агууламж Толгойт болон Телевиз орчимд 30 удаа, Амгалангийн эцэс орчимд 29 удаа, 13-р хороолол болон Баянхошуу орчимд 27 удаа, Хайлааст орчимд 25 удаа, Зуун айл орчимд 20 удаа, Дамбадаржаа орчимд 14 удаа, 1-р хороолол орчимд 12 удаа, Баруун 4 зам орчимд 10 удаа, Физик техникийн хүрээлэн орчимд 9 удаа, Ургах наран хороолол орчимд 7 удаа, Хархорин орчимд 5 удаа, 10 микроноос бага хэмжээтэй тоосны хүлцэх агууламж Телевиз орчимд 30 удаа, Нисэх болон Толгойт орчимд 29 удаа, 1-р хороолол орчимд 28 удаа, Баруун 4 зам, Хархорин болон Баянхошуу орчимд 27 удаа, 13-р хороолол болон Зуун айл орчимд 26 удаа, Амгалангийн эцэс орчимд 24 удаа, Мишээл экспо орчимд 17 удаа, Ургах наран хороолол орчимд 13 удаа, 2.5 микроноос бага хэмжээтэй тоосны хүлцэх агууламж Телевиз орчимд 31 удаа, Баруун 4 зам болон Нисэх орчимд 30 удаа, Толгойт болон Амгалангийн эцэс орчимд 29 удаа, Баянхошуу орчимд 27 удаа, 13-р хороолол орчимд 25 удаа давсан байна.


Зураг I.8 Улаанбаатар хотын агаар дахь хүхэрлэг хийн агууламж, 8 харуулын дундаж, сараар, (мг/м3)




Зураг I.9 Улаанбаатар хотын агаар дахь азотын давхар ислийн агууламж, 8 харуулын дундаж, сараар, (мг/м3)



Зураг I.10 Улаанбаатар хотын агаар дахь 10 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж, 8 харуулын дундаж, сараар, (мг/м3)



Зураг I.11 Улаанбаатар хотын агаар дахь 2.5 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж, 8 харуулын дундаж, сараар, (мг/м3)



### Аюулт үзэгдэл, осол

Аюулт үзэгдэл, ослын тохиолдол 2017 оны 1 дүгээр сард 365 болж, өмнөх оны мөн үеэс 18 (4.7%)-аар буурав. Объектын түймэр 322 удаа гарч, өмнөх оны мөн үеэс 35 (9.8%)-аар буурав. Мал, амьтны халдварт галзуу өвчин 7 удаа, хонины цэцэг өвчин 29 удаа бүртгэгдэж, бичил уурхайн нурангийн ослын улмаас 3 хүн амь насаа алдаж, 4.9 мянган толгой мал, тэжээвэр амьтан хорогдлоо. Амь насаа алдсан хүний тоо өмнөх оны мөн үеэс 2 (40.0%)-оор буурав. Мал, тэжээвэр амьтдын хорогдол өмнөх оны мөн үеэс 4.7 мянга (22.7 дахин)-аар өсөхөд хонины цэцэг өвчний улмаас 4.1 мянган мал хорогдсон нь голлон нөлөөлжээ.

Аюулт үзэгдэл, ослын улмаас 4787.7 сая төгрөгийн хохирол учирч, 41.3 сая төгрөг зарцуулсан байна.

Хүснэгт 1.10 Аюулт үзэгдэл, осол, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар<sup>1</sup>



Үзүүлэлт	2014 I	2015 I	2016 I	2017 I	$\frac{2017 I}{2016 I}$ %
Аюулт үзэгдэл, ослын тохиолдол	547	517	383	365	95.3
Аюулт үзэгдэл, ослын улмаас амь насаа алдсан хүн	10	11	5	3	60.0
Шатсан гэр, орон сууц	307	202	221	168	76.0
Аюулт үзэгдлийн улмаас хорогдсон, устгасан мал, тэжээвэр амьтан, толгой	154	169	216	4 895	22.7 <sup>2</sup>
Объектын түймэр	521	468	357	322	90.2
Учирсан хохирлын хэмжээ, тэрбум төгрөг	1.5	1.9	1.2	4.8	4.2 <sup>2</sup>

<sup>1</sup> Засгийн газрын тохируулагч агентлаг Онцгой байдлын ерөнхий газрын мэдээлэл


<sup>2</sup> Дахин их



### I.7 Гэмт хэрэг

Улсын хэмжээгээр 2017 оны 1 дүгээр сард 2773 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 223 (8.7%)-аар, өмнөх сараас 701 (33.8%)-ээр өсчээ. Нийт гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс өсөхөд хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг 159 (18.3%), тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг 39 (34.2%), өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 36(2.9 %), захиргааны журмын эсрэг гэмт хэрэг 11 (61.1%) -ээр өссөн нь голлон нөлөөлөв.

Зураг 1.12 Бүртгэгдсэн гэмт хэрэг, сараар




Хүүхэд оролцсон гэмт хэрэг 2017 оны 1 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 12 (16.9%), бүлэглэн үйлдэгдсэн хэрэг 5 (2.6%), эмэгтэй хүн оролцсон хэрэг 50 (19.8%), согтуугаар үйлдэгдсэн хэрэг 70 (12.8%)-аар өсчээ.

18, түүнээс дээш насны 10 000 хүнд ногдох гэмт хэрэг 2017 оны 1 дүгээр сард улсын дунджаар 14 болж, өмнөх оны мөн үеэс 2 (16.7%)-оор өссөн байна.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирол 2017 оны 1 дүгээр сард 32.3 тэрбум төгрөг, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 2.0 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс учирсан хохирол 26.1 (5.2 дахин) тэрбум төгрөгөөр, нөхөн төлүүлсэн хохирол 322.8 (19.0%) сая төгрөгөөр өссөн байна.


Зураг 1.13 Учирсан хохирол, нөхөн төлүүлэлт, сараар





Гэмт хэргийн улмаас 2017 оны 1 дүгээр сард 1078 хүн гэмтэж, 150 хүн нас барсан нь өмнөх оны мөн үеэс гэмтсэн хүн 198 (22.5%)-аар, нас барсан хүн 36 (31.6%)-аар нэмэгдсэн байна.

Зураг 1.14 Гэмт хэргийн улмаас хохирсон нийт хүн, үүнээс гэмтсэн, нас барсан хүн, сараар



Улсын хэмжээгээр 2017 оны 1 дүгээр сард 7.5 мянган хүн эрүүлжүүлэгдэж, 629 хүн баривчлагдсан нь өмнөх оны мөн үеэс эрүүлжүүлэгдсэн хүн 164 (2.1%)-өөр буурч, баривчлагдсан хүн 126 (25.0%)-аар өссөн байна.

Гэмт хэргийн улмаас хохирсон иргэд 2017 оны 1 дүгээр сард 2.7 мянга болж, 144 (5.4%) нь 18 хүртэлх насны хүүхэд, 997 (37.1%) нь эмэгтэйчүүд байна.



Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн 151 хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 23 (18.0 %)-аар, харин өмнөх сараас 41 (37.3 %)-ээр нэмэгджээ.

Малын хулгайн гэмт хэрэг 147 бүртгэгдсэн нь нийт бүртгэгдсэн хэргийн 5.3 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 50 (51.5%)-аар, өмнөх сараас 90 (61.2%)-ээр өсчээ.


## II. ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ



### II.1 Дотоодын нийт бүтээгдэхүүн

ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр 2016 оны урьдчилсан гүйцэтгэлээр 16001.8 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 154.6 (1.0%) тэрбум төгрөгөөр өслөө. Уг өсөлтөд хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртөг 98.8 (4.8%) тэрбум төгрөг үйлчилгээний салбарын нэмэгдэл өртөг 115.8 (1.7%) тэрбум төгрөг, бүтээгдэхүүний цэвэр татвар 10.8 (0.8%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлөв.

Зураг I.1 ДНБ-ий өсөлт, хувиар (үйлдвэрлэлийн аргаар, 2010 оны зэрэгцүүлэх үнээр, өмнөх оноос)



\* ААНБ-ын жилийн эцсийн гүйцэтгэл, судалгаанд үндэслэсэн тооцоо


\*\*Урьдчилсан гүйцэтгэл

ДНБ, оны үнээр 2016 оны урьдчилсан гүйцэтгэлээр 23886.4 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 752.3 (3.3%) тэрбум төгрөгөөр өслөө.

Улирлын нөлөөллийг арилган тооцсоноор ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр 2016 оны 4 дүгээр улиралд өмнөх улирлаас 3.2 хувиар өслөө.

Эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ, оны үнээр 2016 оны урьдчилсан гүйцэтгэлээр 24180.0 (4.4%) тэрбум төгрөг, 2010 оны зэрэгцүүлэх үнээр 16105.2 (1.1%) тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос оны үнээр 1009.9 (4.4 %) тэрбум төгрөгөөр өсч, зэрэгцүүлэх үнээр 168.5 (1.1 %) тэрбум төгрөгөөр өслөө.

Зураг I.2 ДНБ-ий бүтэц, дүнд эзлэх хувиар (эцсийн ашиглалтын аргаар, оны үнээр)



\* ААНБ-ын жилийн эцсийн гүйцэтгэл, судалгаанд үндэслэсэн тооцоо

\*\*Урьдчилсан гүйцэтгэл



ДНБ-д 2016 оны урьдчилсан байдлаар эцсийн хэрэглээ 66.9 хувь, хөрөнгийн нийт хуримтлал 29.2 хувь, цэвэр экспорт 3.9 хувийг эзэлж, өмнөх оноос хөрөнгийн нийт хуримтлал 2.2 пунктээр, цэвэр экспорт 2.9 пунктээр өсч, харин эцсийн хэрэглээ 5.1 пунктээр буурсан байна.



## II.2 Мөнгө, зээл, үнэт цаас

Мөнгөний нийлүүлэлт (M2) 2017 оны 1 дүгээр сарын эцэст 11.9 их наяд төгрөг болж, өмнөх сараас 203.0 (1.7%) тэрбум төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 2024.0 (20.5%) тэрбум төгрөгөөр өсчээ.

Хүснэгт II.1 Мөнгөний зарим үндсэн үзүүлэлт, сарын эцэст, тэрбум төгрөг

Үзүүлэлт	2015		2016		2017
	I	I	XII	I	I
<b>Мөнгөний нийлүүлэлт, M2</b>	<b>10 313.4</b>	<b>9 849.6</b>	<b>12 076.5</b>	<b>11 873.5</b>	
Жилийн өөрчлөлт, хувиар	2.9	-4.5	20.2	20.5	
Сарын өөрчлөлт, хувиар	-3.0	-2.0	3.0	-1.7	
<b>Нийт хадгаламж</b>	<b>7 559.1</b>	<b>7 296.1</b>	<b>8 548.4</b>	<b>8 440.3</b>	
Жилийн өөрчлөлт, хувиар	10.0	-3.5	15.8	15.7	
Сарын өөрчлөлт, хувиар	2.4	-1.2	3.4	-1.3	
<b>Төгрөгийн хадгаламж</b>	<b>5 364.5</b>	<b>5 312.5</b>	<b>5 767.0</b>	<b>5 894.8</b>	
Жилийн өөрчлөлт, хувиар	8.1	-1.0	6.1	11.0	
Сарын өөрчлөлт, хувиар	-0.8	-2.2	3.1	2.2	
<b>Валютын хадгаламж</b>	<b>2 194.6</b>	<b>1 983.6</b>	<b>2 781.4</b>	<b>2 545.5</b>	
Жилийн өөрчлөлт, хувиар	15.2	-9.6	42.8	28.3	
Сарын өөрчлөлт, хувиар	11.5	1.8	4.1	-8.5	

Мөнгөний нийлүүлэлт 2017 оны 1 дүгээр сард өмнөх сараас 203.0 тэрбум төгрөгөөр буурахад төгрөгийн хадгаламж 127.8 тэрбум төгрөг, валютын харилцах 50.0 тэрбум төгрөгөөр өссөн хэдий ч валютын хадгаламж 235.8 тэрбум төгрөг, төгрөгийн харилцах 83.1 тэрбум төгрөг, хадгаламжийн байгууллагаас гадуурхи мөнгө 61.8 тэрбум төгрөгөөр буурсан нь нөлөөллөө.


Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө 2017 оны 1 дүгээр сарын эцэст 736.1 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 87.6 (10.6%) тэрбум төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 22.3 (3.1%) тэрбум төгрөгөөр өсчээ.

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2017 оны 1 дүгээр сарын эцэст 12.4 их наяд төгрөг болж, өмнөх сараас 42.7 (0.3%) тэрбум төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 590.2 (5.0%) тэрбум төгрөгөөр өсчээ.

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2017 оны 1 дүгээр сарын эцэст 945.7 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 41.4 (4.6%) тэрбум төгрөг, өмнөх оны мөн үеэс 6.9 (0.7%) тэрбум төгрөгөөр өсчээ. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 7.6 хувийг эзэлж, өмнөх сараас 0.3 пунктээр өсч, өмнөх оны мөн үеэс 0.4 пунктээр буурчээ.

Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2017 оны 1 дүгээр сарын эцэст 1056.2 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 4.5 (0.4%) тэрбум төгрөг, өмнөх оны мөн үеэс 162.2 (18.1%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 8.5 хувийг эзэлж, өмнөх сараас өөрчлөлтгүй боловч өмнөх оны мөн үеэс 0.9 пунктээр нэмэгдсэн байна.

Зураг II.3 Чанаргүй зээл, сарын эцэст, тэрбум төгрөг




Үнэт цаасны арилжаагаар 2017 оны 1 дүгээр сард 37.7 тэрбум төгрөгийн гүйлгээ хийж, 26.0 сая ширхэг үнэт цаас арилжсан нь өмнөх оны мөн үеэс гүйлгээ 5.6 (17.6%) тэрбум төгрөгөөр өсч, өмнөх сараас 112.4 (74.9%) тэрбум төгрөгөөр буурчээ. Арилжсан үнэт цаас өмнөх оны мөн үеэс 8.7 (25.0%) сая ширхэг, өмнөх сараас 12.3 (32.2%) сая ширхгээр буурчээ.

Засгийн газрын үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаагаар 2017 оны 1 дүгээр сард 1.2 тэрбум төгрөгийн гүйлгээ хийсэн нь өмнөх оны мөн үеэс 12.8 (91.1%) тэрбум төгрөгөөр, өмнөх сараас 49.3 тэрбум (97.5%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

Хөрөнгийн зах зээлийн чиг хандлагыг илэрхийлэх ТОП-20 дундаж индекс 2017 оны 1 дүгээр сард 12237.7 нэгж болж, өмнөх сараас 632.0 нэгж, өмнөх оны мөн үеэс 79.7 нэгжээр өсчээ.

Хөрөнгийн зах зээлд үйл ажиллагаа явуулж байгаа хувьцаат компаниудын үнэт цаасны зах зээлийн нийт үнэлгээ 2017 оны 1 дүгээр сард 1441.9 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 32.3 (2.2%) тэрбум төгрөгөөр буурчээ.

Зураг II.4 ТОП-20 индекс, сарын дундаж, нэгжээр



Төгрөгийн америк доллартай харьцах, Монголбанкны нэрлэсэн дундаж ханш 2017 оны 1 дүгээр сард 2488.38 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 485.16 (24.2%) төгрөгөөр суларчээ. Мөн өмнөх сараас 0.2 хувиар суларсан байна.

Төгрөгийн юаньтай харьцах, Монголбанкны нэрлэсэн дундаж ханш 2017 оны 1 дүгээр сард 360.78 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 56.03 (18.4%) төгрөгөөр суларч, өмнөх сараас 0.6 хувиар суларсан байна.



Төгрөгийн рубльтэй харьцах, Монголбанкны нэрлэсэн дундаж ханш 2017 оны 1 дүгээр сард 41.58 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 15.61 (60.1%) төгрөгөөр суларсан бол өмнөх сараас 3.9 хувиар суларсан байна.

## Хүснэгт II.2 Валютын ханш, Монголбанкны төгрөгийн валюттай харьцах нэрлэсэн ханш, сарын дундаж, төгрөг


Үзүүлэлт	2015	2016		2017
	XII	I	XII	I
<b>Ам. доллар</b>	<b>1 995.84</b>	<b>2 003.22</b>	<b>2 482.57</b>	<b>2 488.38</b>
Жилийн өөрчлөлт, хувиар	6.0	3.6	24.4	24.2
Сарын өөрчлөлт, хувиар	0.1	0.4	2.0	0.2
<b>Евро</b>	<b>2 171.72</b>	<b>2 175.72</b>	<b>2 619.89</b>	<b>2 642.58</b>
Жилийн өөрчлөлт, хувиар	- 6.5	- 3.2	20.6	21.5
Сарын өөрчлөлт, хувиар	1.4	0.2	- 0.5	0.9
<b>Юань</b>	<b>309.34</b>	<b>304.75</b>	<b>358.73</b>	<b>360.78</b>
Жилийн өөрчлөлт, хувиар	1.6	- 1.9	16.0	18.4
Сарын өөрчлөлт, хувиар	- 1.1	- 1.5	0.8	0.6
<b>Рубль</b>	<b>28.57</b>	<b>25.97</b>	<b>40.00</b>	<b>41.58</b>
Жилийн өөрчлөлт, хувиар	- 15.6	- 13.3	40.0	60.1
Сарын өөрчлөлт, хувиар	- 6.9	- 9.1	5.8	3.9



## II.3 Улсын нэгдсэн төсөв

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн нийт хэмжээ 2017 оны 1 дүгээр сард 440.6 тэрбум төгрөг, зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 465.9 тэрбум төгрөг болж, улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 25.3 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа. Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үеэс 54.4 тэрбум төгрөгөөр буурахад орлогын өсөлт зарлагын өсөлтөөс 19.1 пунктээр илүү байгаа нь нөлөөлжээ.

Зураг II.5 Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, зарлага, тэнцэл, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар, тэрбум төгрөг



Татварын нийт орлого 360.9 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 60.4 (20.1%) тэрбум төгрөгөөр өсөхөд онцгой албан татварын орлого 10.8 (22.0%) тэрбум төгрөг, нийгмийн даатгалын орлого 9.7 (11.2%) тэрбум төгрөгөөр буурсан хэдий ч орлогын албан татвар 36.7 (98.2%) тэрбум төгрөг, бусад татвар, төлбөр хураамжийн орлого 19.9 (73.4%) тэрбум төгрөг, нэмэгдсэн өртгийн албан татвар 12.0 (15.6%) тэрбум төгрөг, гадаад үйл ажиллагааны орлого 10.6 (55.0%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Улсын нэгдсэн төсвийн орлогын 8.9 хувийг ирээдүйн өв сангийн орлого, 74.6 хувийг татварын орлого, 16.5 хувийг татварын бус орлого эзэлж, өмнөх оны мөн үеэс татварын орлогын эзлэх хувь 15.0 пунктээр буурч, ирээдүйн өв сангийн орлогынх 8.9 пункт, татварын бус орлогынх 6.1 пунктээр өссөн байна.

Улсын нэгдсэн төсвийн зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 2017 оны 1 дүгээр сард 465.9 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 50.9 (12.3%) тэрбум төгрөгөөр өсөхөд хөрөнгийн зардал 31.8 (2.8 дахин) тэрбум төгрөг, урсгал зардал 17.0 (4.3%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна.




Улсын нэгдсэн төсвийн зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт дүнд урсгал зардал 89.0 хувь, хөрөнгийн зардал 10.5 хувь, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл 0.4 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс урсгал зардлынх 6.8 пунктээр буурч, хөрөнгийн зардлынх 6.4 пункт, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлийнх 0.4 пунктээр өссөн байна.



## II.4 Гадаад худалдаа

Монгол Улс 2017 оны 1 дүгээр сард дэлхийн 99 оронтой худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 705.7 сая америк доллар, үүнээс экспорт 428.5 сая америк доллар, импорт 277.2 сая америк доллар байна.

Зураг II.6 Гадаад худалдааны нийт бараа эргэлт, жил бүрийн эцсийн байдлаар, сая америк доллар



<sup>1</sup> Урьдчилсан гүйцэтгэл

Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 177.4 (33.6%) сая америк доллар, үүнээс экспорт 99.4 (30.2%) сая америк доллараар, импорт 78.0 (39.2%) сая америк доллараар өссөн байна.

Гадаад худалдааны тэнцэл 2016 оны 1 дүгээр сард 130.0 сая америк долларын ашигтай гарч байсан бол 2017 оны 1 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 21.4 сая америк доллараар нэмэгдэж, 151.4 сая америк долларт хүрчээ.

Экспорт 2017 оны 1 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 99.4 (30.2%) сая америк доллараар өсөхөд эрдэс бүтээгдэхүүний экспорт 115.2 сая америк доллар, үүнээс нүүрсний экспорт 134.9 сая америк доллараар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Импорт өмнөх оны мөн үеэс 78.0 (39.2%) сая америк доллараар өсөхөд эрдэс бүтээгдэхүүний импорт 27.3 сая америк доллар, үүнээс дизелийн түлш 21.9 сая америк доллар, автобензин 5.0 сая америк доллараар, машин, механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг, эд анги 27.0 сая америк доллараар өссөн нь голлон нөлөөлжээ.


## Хүснэгт II.3 Экспорт, импорт, зарим барааны бүлгээр, сая америк доллар

	2015 I	2016 I	2017 <sup>1</sup> I	$\frac{2017^1 I}{2016^1 I} \%$		2015 I	2016 I	2017 <sup>1</sup> I	$\frac{2017^1 I}{2016^1 I} \%$
Экспорт	472.7	329.1	428.5	130.2	Импорт	247.3	199.1	277.2	139.2
Эрдэс бүтээгдэхүүн	382.0	260.2	375.4	144.3	Эрдэс бүтээгдэхүүн	72.0	44.2	71.5	161.6
Үндсэн төмөрлөг	5.9	6.1	7.8	126.8	Авто, агаар, усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг	25.1	24.0	30.0	125.0
Түүхий болон боловсруулсан арьс, шир	5.2	8.9	4.4	49.0	Хүнсний бэлэн бүтээгдэхүүн	23.2	22.0	23.5	107.2
Нэхмэл, нэхмэл бүтээгдэхүүн	8.8	11.4	11.8	103.3	Үндсэн төмөрлөг бүтээгдэхүүн	17.0	8.8	16.4	186.4
Үнэт чулуу, металл, гоёлын зүйлс	40.2	25.6	18.2	71.1	Машин, механик төхөөрөмж	42.9	37.7	64.7	171.5

<sup>1</sup> Урьдчилсан гүйцэтгэл




Эрдэс бүтээгдэхүүн, нэхмэл, нэхмэл бүтээгдэхүүн, үнэт, хагас үнэт чулуу, металл гоёлын зүйлсийн экспорт нийт экспортын 94.6 хувийг эзэлж байгаа бол импортын 60.0 хувийг эрдэс бүтээгдэхүүн, машин тоног төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, авто, агаар, усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд ангийн импорт эзэлж байна.



## II.5 Үнэ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ улсын хэмжээнд 2017 оны 1 дүгээр сард (хэрэглээний бараа, үйлчилгээний сагс, жин, суурь үеийг 2015 онд шилжүүлэн тооцсоноор) өмнөх сараас 1.1 хувь, өмнөх оны мөн үеэс 3.3 хувиар өссөн байна.

Зураг II.7 Хэрэглээний үнийн улсын индекс (өмнөх оны 12 дугаар сар =100)



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2017 оны 1 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 3.3 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 6.1 хувь (мах, махан бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 10.9 хувь), орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 4.3 хувь (цахилгаан, хийн болон бусад түлшний дэд бүлгийн үнэ 6.5 хувь), боловсролын үйлчилгээний бүлгийнх 3.8 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.


Хүснэгт II.4 Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс, 2017 оны 1 дүгээр сард

Бараа, үйлчилгээний бүлэг	Жин	хувь	
		2017 I	2017 I 2016 XII
<b>Ерөнхий индекс</b>	<b>100.0</b>	<b>103.3</b>	<b>101.1</b>
Хүнсний бараа, ундаа, ус	26.1	106.1	103.4
Согтууруулах ундаа, тамхи	4.4	101.3	100.2
Хувцас, бөс бараа, гутал	16.6	103.0	100.2
Орон сууц, ус, цахилгаан, түлш	9.3	104.3	100.1
Гэр ахуйн тавилга, бараа	4.9	102.5	100.6
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	3.6	102.9	100.6
Тээвэр	14.4	100.2	100.2
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	4.4	98.4	99.6
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	3.1	99.9	100.1
Боловсролын үйлчилгээ	4.8	103.8	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	3.0	101.9	100.0
Бусад бараа, үйлчилгээ	5.4	104.6	101.2

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2017 оны 1 дүгээр сард өмнөх сараас 1.1 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 3.4 хувь (мах, махан бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 7.0 хувь), эм, тариа, эмнэлгийн үйлчилгээний болон гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнэ дүнгээрээ 0.6 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2017 оны 1 дүгээр сард өмнөх сараас Улаанбаатар хот болон бүх аймагт 0.1-2.9 хувиар өсчээ. Баянхонгор аймагт 2.9 хувиар өссөн нь хамгийн өндөр үзүүлэлт байна.

Зураг II.8 Хэрэглээний үнийн индекс, хувь, аймаг, нийслэлээр 2017 оны 1 дүгээр сард (өмнөх сар = 100%)



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ Улаанбаатар хотод 2017 оны 1 дүгээр сард өмнөх сараас 0.9 хувь, өмнөх оны мөн үеэс 3.0 хувиар өслөө.


Улаанбаатар хотод хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2017 оны 1 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 3.0 хувиар өсөхөд орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 5.6 хувь (үүнээс цахилгаан, хийн болон бусад түлшний дэд бүлгийн үнэ 8.7 хувь), хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 5.2 хувь (үүнээс мах, махан бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 11.1 хувь), хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 2.5 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Харин өмнөх сараас 0.9 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 3.4 хувь, үүнээс мах, махан бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ дүнгээрээ 6.9 хувиар өссөн нь голлон нөлөөллөө.

Улаанбаатар хотод 2017 оны 1 дүгээр сард өмнөх сараас хэрэглээний сагсны 344 нэрийн бараа, үйлчилгээний 27.3 хувийнх нь үнэ өсч, 13.4 хувийнх нь буурч, 59.3 хувийнх нь үнэ тогтвортой байв. Судалгаанд сонгогдсон хүнсний 99 нэрийн барааны 67.7 хувь буюу 67 нэрийн барааны үнэ нэмэгджээ.



**Хэрэглээний үнийн индексийн сарын өөрчлөлт,  
аймаг, нийслэлээр, 2017 оны 1 дүгээр сард**



**Хөдөө аж ахуйн зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнэ**


Хөдөө аж ахуйн зарим бүтээгдэхүүний зах зээлийн үнийн судалгаагаар 2017 оны 1 дүгээр сард үхрийн 2 метрээс дээш урттай ширний дундаж үнэ Увс, Говь-Алтай, Завхан, Ховд, Баянхонгор, Орхон, Хөвсгөл, Говьсүмбэр, Дундговь аймагт хамгийн бага буюу 28.0-30.0 мянган төгрөг; Дархан-Уул, Хэнтий аймаг, Улаанбаатар хотод хамгийн их буюу 41.0-42.0 мянган төгрөг; адууны ширний дундаж үнэ Увс, Орхон, Сэлэнгэ, Дундговь аймагт хамгийн бага буюу 28.0-32.0 мянган төгрөг; Сүхбаатар, Хэнтий аймаг, Улаанбаатар хотод хамгийн их буюу 42.0 мянган төгрөг; ямааны 1 килограмм цагаан ноолуурын үнэ Архангай, Булган, Орхон, Ховд, Хөвсгөл, Сүхбаатар аймагт хамгийн бага буюу 40.0-50.0 мянган төгрөг; Өвөрхангай, Баян-Өлгий аймагт хамгийн их буюу 56.0-57.0 мянган төгрөг байна.



## II.6 Мал аж ахуй

Том малын зүй бус хорогдол 2017 оны 1 дүгээр сард улсын хэмжээнд 64.5 мянга болж, өмнөх оны мөн үеэс 53.9 (45.5%) мянгаар буурав. Том малын зүй бус хорогдлыг төрлөөр нь авч үзвэл адуу 3.2 мянга, үхэр 6.3 мянга, тэмээ 31, хонь 28.7 мянга, ямаа 26.2 мянга байна. Нийт хорогдсон малын 44.5 хувийг хонь, 40.7 хувийг ямаа эзэлж байна.

Зураг II.9 Том малын зүй бус хорогдол, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар, мянган толгой



Улсын хэмжээнд өвчнөөр хорогдсон мал 2017 оны 1 дүгээр сард 7.2 мянга болж, өмнөх оны мөн үеэс 5.5 (4.0 дахин) мянгаар нэмэгдэв.




## II.7 Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2017 оны 1 дүгээр сард урьдчилсан гүйцэтгэлээр 936.8 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 316.3 (51.0%) тэрбум төгрөгөөр өслөө.

Үүнд уул уурхай, олборлох аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэл өмнөх оноос 293.8 (76.8%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлөв.

Зураг II.10 Аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэл, салбараар, тэрбум төгрөг, сараар

тэрбум төгрөг



° Урьдчилсан гүйцэтгэл

Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийн индекс (улирлын нөлөөллийг арилгасан туршилт тооцоо) 2017 оны 1 дүгээр сард 155.5 (2010=100) болж, өмнөх оны мөн үеэс 18.1 хувиар өсч, өмнөх сараас 1.8 хувиар буурчээ.

Өмнөх оны мөн үеэс уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарт алт, молибдений баяжмал, цайрын баяжмал, нүүрс, төмрийн хүдэр зэрэг гол нэр төрлийн бүтээгдэхүүний олборлолт 16.4 хувиас 5.1 дахин, боловсруулах аж үйлдвэрийн салбарт зүсмэл материал, архи, малын тэжээл, ноолууран сүлжмэл эдлэл, банш, бууз, шар айраг, хиаман төрлийн бүтээгдэхүүн, вакум цонх, хаалга, адууны мах зэрэг гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 10.9 хувиас 5.7 дахин өссөн байна.

Харин уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарт хайлуур жонш, газрын тос, зэсийн баяжмал, буталмал чулуу зэрэг бүтээгдэхүүний олборлолт 1.7-20.5 хувь, боловсруулах аж үйлдвэрийн салбарт цэвэр ус, катодын зэс, талх, нарийн боов, самнасан ноолуур, барилгын модон хаалга, цонх зэрэг гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 0.9-88.4 хувиар буурсан байна.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2017 оны 1 дүгээр сард 1049.1 тэрбум төгрөгт хүрсний 748.5 тэрбум төгрөг буюу 71.3 хувийг гадаад зах зээлд борлуулжээ.




## II.8 Дотоод худалдаа

Улсын хэмжээнд 2016 онд нийт 72.2 мянган аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулсны 27.7 (38.4%) мянга нь бөөний болон жижиглэн худалдааны салбарынх байна.

Худалдааны салбарын нийт борлуулалт 2016 оны урьдчилсан гүйцэтгэлээр 13199.2 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 327.4 (2.4%) тэрбум төгрөгөөр буурчээ.

Өмнөх оноос жижиглэн худалдааны борлуулалт 454.1 (7.0%) тэрбум төгрөгөөр буурч, бөөний худалдааных 126.7 (1.8%) тэрбум төгрөгөөр өсөв.

Зураг II.11 Худалдааны салбарын нийт борлуулалт, улирлаар, тэрбум төгрөг



Тайлбар: ААНБ-ын судалгаанд суурилсан гүйцэтгэл  
<sup>1</sup>урьдчилсан гүйцэтгэл

Худалдааны салбарын борлуулалт 2016 оны 4 дүгээр улиралд 4907.5 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 538.5 (12.3%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Худалдааны салбарын борлуулалтын 92.8 хувь нь Улаанбаатар хотод ногдож байна.


Худалдааны салбарын нийт борлуулалт өмнөх оноос Сүхбаатар, Баян-Өлгий, Хэнтий, Өвөрхангай, Говь-Алтай, Булган, Өмнөговь, Говьсүмбэр, Завхан, Архангай, Дундговь, Увс, Сэлэнгэ, Хөвсгөл, Баянхонгор, Ховд, Орхон, Дорноговь аймагт 1.8 хувиас 2.4 дахин өсч, Улаанбаатар хот болон бусад аймагт 3.7-43.5 хувиар буурчээ.



## II.9 Тээвэр

Төмөр замын тээврээр 2017 оны 1 дүгээр сард 1622.1 мянган тонн ачаа, давхардсан тоогоор 207.8 мянган хүн тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс тээсэн ачаа 34.7 (2.1%) мянган тонн, зорчигчид 17.7 (7.9%) мянгаар буурчээ.

Зураг II.12 Төмөр зам болон агаарын тээврээр тээсэн ачаа




<sup>1</sup> Урьдчилсан гүйцэтгэл

Төмөр замаар 2017 оны 1 дүгээр сард нийт тээсэн ачаанд дотоодын ачаа 49.3 хувь, экспортын ачаа 30.5 хувь, импортынх 9.6 хувь, дамжин өнгөрсөн ачааных 10.6 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс дотоодын ачааных 1.0 пункт, импортынх 1.7 пункт, дамжин өнгөрсөн ачааных 0.8 пунктээр нэмэгдэж, харин экспортын ачааных 3.5 пунктээр буурсан байна. Экспортын ачаа буурахад төмрийн хүдрийн тээвэрлэлт буурсан нь нөлөөлсөн байна.

Төмөр замын тээврийн салбарын орлого 2017 оны 1 дүгээр сард 32.5 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.2 (3.5%) тэрбум төгрөгөөр буурчээ.

Агаарын тээврээр 2017 оны 1 дүгээр сард 210.3 тонн ачаа, давхардсан тоогоор 53.1 мянган хүн тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс тээсэн ачаа 13.5 (6.0%) тонноор буурч, зорчигчид 6.6 (14.1%) мянгаар өсчээ. Түүнчлэн өмнөх сараас тээсэн ачаа 43.4 (17.1%) тонноор буурч, зорчигчид 1.8 (3.4%) мянган хүнээр өсчээ.

Зураг II.13 Төмөр зам болон агаарын тээврээр зорчсон зорчигчид



Агаарын тээврээр 2017 оны 1 дүгээр сард дотоодын зорчигчид 21.7 (40.9%) мянган хүн болж, өмнөх оны мөн үеэс 8.0 (58.2%) мянгаар өсч, харин олон улсын зорчигчид 31.3 (59.1%) мянга болж, 1.4 (4.3%) мянгаар буурчээ. Агаарын тээврийн салбарын орлого 2017 оны 1 дүгээр сард 20.2 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.3 (7.1%) тэрбум төгрөг, өмнөх сараас 1.1 (6.0%) тэрбум төгрөгөөр өсчээ.




### II.10 Зоогийн газар, зочид буудал

Нийтийн хоолны салбарын орлого 2016 онд урьдчилсан гүйцэтгэлээр 231.4 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 25.9 (12.6%) тэрбум төгрөгөөр өслөө. Нийтийн хоолны салбарын орлогын өсөлтөд рестораны орлого өмнөх оны мөн үеэс 19.1 (17.2%) тэрбум төгрөгөөр, кафеных 9.5(46.6%) тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.

Нийтийн хоолны салбарын орлого 2016 оны 4 дүгээр улиралд 54.7 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 6.4 (13.3%) тэрбум төгрөгөөр өсчээ. Үүнд захиалгат хоол хүргэлтийн үйлчилгээний орлого өмнөх оны мөн үеэс 4.1(41.5%) тэрбум төгрөгөөр буурсан ч рестораны орлого 7.1 (26.3%) тэрбум төгрөгөөр, кафеных 2.6 (56.6%) тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна. Түүнчлэн 2016 оны 4 дүгээр улирлын орлого өмнөх улирлаас 13.8 (20.2%) тэрбум төгрөгөөр буурч, үүнд захиалгат хоол хүргэлтийн үйлчилгээний орлого өмнөх улирлаас 8.1 (58.1%) тэрбум төгрөгөөр, рестораных 3.1 (8.3%) тэрбум төгрөгөөр, кафеных 2.3 (24.1%) тэрбум төгрөгөөр буурсан нь нөлөөллөө.

Зураг II.14 Нийтийн хоолны салбарын орлого, зоогийн газрын төрлөөр, улирлаар, тэрбум төгрөг



° Урьдчилсан гүйцэтгэл

Нийтийн хоолны салбарт 2016 онд 829 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж, 9151 хүн ажиллажээ. Аж ахуйн нэгжийн тоо өмнөх оны мөн үеэс 66 (8.7%)-гаар, ажиллагчид 327 (3.7%)-гоор нэмэгдсэн байна.

Зураг II.15 Нийтийн хоолны салбарын мэдээнд хамрагдсан ААНБ, ажилчид, жил бүрийн эцэст




° Урьдчилсан гүйцэтгэл

Нэг суудалд ногдох дундаж орлого 2016 онд 4.6 сая төгрөг болж, өмнөх оны эцсээс 605.2 (15.2%) мянган төгрөгөөр өсчээ. Үүнд кафены нэг суудалд ногдох дундаж орлого өмнөх оны эцсээс 1.6 (55.5%) сая төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ.

Зочид буудлын салбарын орлого 2016 оны урьдчилсан гүйцэтгэлээр 135.7 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.5(1.1%) тэрбум төгрөгөөр өссөн бол тус салбарын зардал 273.1 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс хоёр дахин өссөн байна.

Зочид буудлын салбарын орлого 2016 оны 4 дүгээр улиралд 27.6 тэрбум төгрөгт болж, өмнөх оны мөн үеэс 483.4 (1.7%) сая төгрөгөөр, өмнөх улирлаас 22.2 (44.5%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Үүнд 3, түүнээс дээш одтой буудлын орлого өмнөх оны мөн үеэс 716.9 (3.3%) сая төгрөгөөр, өмнөх улирлаас 19.0 (47.6%) тэрбум төгрөгөөр буурсан нь нөлөөллөө.

Зураг II.16 Зочид буудлын салбарын орлого, буудлын зэрэглэлээр, улирлаар, тэрбум төгрөг



° Урьдчилсан гүйцэтгэл


Хөрөнгийн орлого	108.8	83.4	56.3	72.0
Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	85.1	6.5	54.8	60.8
Өмч хувьчлал	23.7	76.9	1.5	11.2
Тусламжийн орлого	-	-	-	1.7
Хандив тусламж, гадаад	-	-	-	1.7
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	105 002.2	87 065.3	100 764.1	115 728.1
Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	85 119.8	70 199.6	83 531.5	96 872.9
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	3 462.4	-	-	2 701.1
Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг	16 420.0	16 865.7	17 232.6	16 154.2

<sup>1</sup>Урьдчилсан гүйцэтгэл

## 4.1 УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ЗАРЛАГА, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар

Зарлагын төрөл	2014 I	2015 I	2016 I	2017 <sup>1</sup> I
	сая төгрөг			
<b>НИЙТ ЗАРЛАГА, ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ХЭМЖЭЭ</b>	<b>413 116.9</b>	<b>366 356.5</b>	<b>415 004.0</b>	<b>465 881.6</b>
НИЙТ ЗАРЛАГА	428 345.9	386 545.6	415 004.0	463 829.2
УРСГАЛ ЗАРДАЛ	361 958.2	316 126.6	397 682.8	414 718.3
Бараа, ажил үйлчилгээний зардал	158 016.5	144 904.0	189 291.0	186 199.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	108 067.3	117 525.9	131 494.9	131 871.8
Үндсэн цалин	108 067.3	109 100.6	120 200.7	115 543.6
Нэмэгдэл	-	3 735.6	5 615.9	10 219.7
Унаа хоолны хөнгөлөлт	-	2 091.7	2 309.9	2 857.7
Урамшуулал	-	411.3	286.4	409.0
Гэрээт ажлын хөлс	-	2 186.6	3 082.0	2 841.7
Нийгмийн даатгалын шимтгэл	8 745.0	8 505.6	-	-
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14 856.9	10 236.1	20 196.7	19 945.9
Гэрэл, цахилгааны зардал	2 278.0	1 978.4	3 453.8	3 545.5
Түлш, халаалтын зардал	10 409.5	7 132.8	14 125.5	13 293.0
Цэвэр, бохир усны зардал	1 045.8	922.6	1 399.3	1 359.2
Байрны түрээс	1 123.5	202.4	1 218.1	1 748.1
Хангамж, бараа материалын зардал	2 807.1	2 337.3	5 722.5	5 782.3
Нормативт зардал	10 560.0	4 323.3	11 761.1	8 617.0
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4 135.3	623.3	4 280.9	2 631.5
Хоолны зардал	5 770.2	3 255.0	6 757.5	5 623.7
Нормын хувцас, зөөлөн эдлэл авах зардал	654.5	445.0	722.8	361.9
Эд хогшил, урсгал засварын зардал	1 343.9	198.2	1 004.2	926.8
Томилолт, зочны зардал	-	274.3	694.3	602.5
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	5 747.3	8 223.6	8 267.4
Бараа үйлчилгээний бусад зардал	20 381.3	4 261.6	10 193.7	10 185.3
Бараа үйлчилгээний бусад зардал	20 381.3	4 195.1	8 267.9	7 390.5
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	66.5	1 925.8	2 794.9
ХҮҮ	25 272.8	30 718.6	30 981.9	62 333.7
Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	5 163.8	26 261.2	28 333.7	37 406.8
Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	20 108.9	4 457.4	2 648.2	24 927.0
ТАТААС	24 196.0	1 539.0	1 550.5	2 964.8
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	5 313.3	247.0	331.9	376.5
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	18 882.7	1 292.0	1 218.6	2 588.3
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	154 473.0	138 964.9	175 859.4	163 220.7
Засгийн газрын урсгал шилжүүлэг	58 177.6	537.7	2 473.1	718.7
Бусад урсгал шилжүүлгүүд	96 295.4	138 427.2	173 386.3	162 502.0
Нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмж	77 442.9	98 890.2	128 231.7	125 412.2
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	18 846.0	35 650.4	39 060.7	30 427.3
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	160.4	173.0	263.7
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	6.5	2 678.3	2 135.6	1 136.5
Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт	-	-	0.6	-
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	761.7	3 098.8	1 816.5
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	194.1	493.2	3 335.4
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	92.1	192.7	110.4

## Хавсралт 4-ийн үргэлжлэл

Зарлагын төрөл	2014 I	2015 I	2016 I	2017 <sup>1</sup> I
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	66 387.7	70 419.0	17 321.2	49 110.9
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	- 15 229.0	- 20 189.1	-	2 052.4
Эргэж төлөгдөх цэвэр зээл	- 15 984.0	- 20 741.8	-	82.9
Гадаадын санхүүгийн зах зээлээс санхүүжих	755.0	-	-	-
Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	-	552.7	-	1 969.5

## 4.2 УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН АЛДАГДЛЫН САНХҮҮЖИЛТ, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар

Эх үүсвэр	2014 I	2015 I	2016 I	2017 <sup>1</sup> I
	сая төгрөг			
<b>АЛДАГДЛЫН САНХҮҮЖИЛТ, ЭХ ҮҮСВЭРЭЭР</b>	<b>59 340.2</b>	<b>12 794.4</b>	<b>79 759.6</b>	<b>25 324.9</b>
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	57 450.2	- 56 024.1	104 218.3	-13 980.1
Засгийн газрын бонд	19 665.6	6 725.5	-19 653.9	- 17 782.0
Засгийн газрын зээл	- 17 775.6	66 523.9	3 684.9	57 086.9
Урьдчилгаа төлбөр	-	- 4 431.0	-8 489.7	-

<sup>1</sup>Урьдчилсан гүйцэтгэл

## 5.1 УЛСЫН ТӨСВИЙН ЗАРЛАГА, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар

Зарлагын төрөл	2014 I	2015 I	2016 I	2017 <sup>1</sup> I
	сая төгрөг			
<b>НИЙТ ЗАРЛАГА, ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ХЭМЖЭЭ</b>	<b>304 072.9</b>	<b>252 332.9</b>	<b>275 644.6</b>	<b>401 175.0</b>
НИЙТ ЗАРЛАГА	319 301.9	272 522.0	275 644.6	399 205.5
УРСГАЛ ЗАРДАЛ	267 790.3	203 991.0	267 629.2	350 283.0
Бараа, ажил үйлчилгээний зардал	88 040.4	85 500.1	105 516.4	108 571.7
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	59 435.3	68 729.4	72 889.2	75 428.9
Үндсэн цалин	59 435.3	64 682.5	67 730.6	65 345.1
Нэмэгдэл	-	1 272.1	2 099.6	6 782.8
Унаа хоолны хөнгөлөлт	-	1 748.2	1 913.9	2 353.2
Урамшуулал	-	339.3	144.6	88.6
Гэрээт ажлын хөлс	-	687.2	1 000.5	859.2
Нийгмийн даатгалын шимтгэл	3 976.1	4 059.3	4 491.3	4 557.9
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5 892.1	3 615.0	7 575.2	8 004.0
Гэрэл, цахилгааны зардал	1 279.9	945.6	1 744.5	1 792.4
Түлш, халаалтын зардал	3 077.1	2 123.5	4 058.7	3 925.9
Цэвэр, бохир усны зардал	507.4	400.7	668.3	617.7
Байрны түрээс	1 027.7	145.3	1 103.7	1 667.9
Хангамж, бараа материалын зардал	1 774.7	701.7	2 708.1	2 885.7
Нормативт зардал	6 223.1	1 887.1	6 808.7	4 452.7
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3 992.7	613.8	4 122.1	2 487.6
Хоолны зардал	1 663.2	851.3	2 081.5	1 664.5
Нормын хувцас, зөөлөн эдлэл авах зардал	567.3	422.0	605.1	300.5
Эд хогшил, урсгал засварын зардал	979.8	51.0	473.7	591.0
Томилолт, зочны зардал	-	176.8	426.5	471.2
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	4 587.9	5 151.6	5 708.1
Бараа үйлчилгээний бусад зардал	9 759.4	1 692.0	4 992.1	6 472.3
Бараа үйлчилгээний бусад зардал	9 759.4	1 668.7	3 321.3	3 854.1
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	23.3	1 670.8	2 618.2
ХҮҮ	25 272.8	30 718.6	30 981.9	62 333.7
Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	5 163.8	26 261.2	28 333.7	37 406.8
Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	20 108.9	4 457.4	2 648.2	24 927.0
ТАТААС	22 127.6	-	26 990.7	49 182.4
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	5 168.5	-	26 990.7	49 182.4
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	16 959.1	-	-	-
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	132 349.5	87 772.3	104 140.3	130 195.2
Засгийн газрын урсгал шилжүүлэг	132 048.0	87 065.3	101 306.6	115 728.6
Бусад урсгал шилжүүлгүүд	301.5	707.0	2 833.7	14 466.6
Нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмж	-	-	-	0.3
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	295.0	57.2	337.4	12 687.4
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	85.2	106.3	153.8
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	6.5	22.5	808.1	203.3
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	523.6	1 555.1	792.3
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	-	25.8	629.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	18.6	0.5	0.5

## Хавсралт 5-ын үргэлжлэл

Зарлагын төрөл	2014 I	2015 I	2016 I	2017 <sup>1</sup> I
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	51 511.6	68 531.0	8 015.3	48 922.5
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	- 15 229.0	- 20 189.1	-	1 969.5
Эргэж төлөгдөх цэвэр зээл	- 15 984.0	- 20 741.8	-	-
Гадаадын санхүүгийн зах зээлээс санхүүжих	755.0	-	-	-
Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	-	552.7	-	1 969.5

## 5.2 УЛСЫН ТӨСВИЙН АЛДАГДЛЫН САНХҮҮЖИЛТ, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар

Эх үүсвэр	2014 I	2015 I	2016 I	2017 <sup>1</sup> I
	сая төгрөг			
<b>АЛДАГДЛЫН САНХҮҮЖИЛТ, ЭХ ҮҮСВЭРЭЭР</b>	<b>62 519.2</b>	<b>51 038.3</b>	<b>67 818.2</b>	<b>89 720.7</b>
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	60 629.2	- 22 211.1	83 843.5	50 415.8
Засгийн газрын бонд	19 665.6	6 725.5	-19 653.9	- 17 782.0
Засгийн газрын зээл	- 17 775.6	66 523.9	3 628.6	57 086.9

<sup>1</sup>Урьдчилсан гүйцэтгэл

## 6.1 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар

Зарлагын төрөл	2014 I	2015 I	2016 I	2017 <sup>1</sup> I
	сая төгрөг			
<b>НИЙТ ЗАРЛАГА, ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ХЭМЖЭЭ</b>	<b>122 916.3</b>	<b>88 402.9</b>	<b>124 974.3</b>	<b>112 242.5</b>
НИЙТ ЗАРЛАГА	122 916.3	88 402.9	124 974.3	112 159.6
УРСГАЛ ЗАРДАЛ	108 040.3	86 515.0	115 668.5	111 971.2
Бараа, ажил үйлчилгээний зардал	77 467.3	66 732.7	92 889.1	86 468.6
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	47 750.1	47 798.3	57 601.5	55 332.5
Үндсэн цалин	47 750.1	43 419.9	51 466.0	49 235.0
Нэмэгдэл	-	2 463.5	3 516.2	3 388.6
Унаа хоолны хөнгөлөлт	-	343.5	396.0	447.3
Урамшуулал	-	72.0	141.8	320.3
Гэрээт ажлын хөлс	-	1 499.4	2 081.5	1 941.3
Нийгмийн даатгалын шимтгэл	4 683.7	4 352.9	5 765.8	5 592.4
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8 847.3	6 553.4	12 530.5	11 837.3
Гэрэл, цахилгааны зардал	988.9	1 026.0	1 694.8	1 740.3
Түлш, халаалтын зардал	7 296.7	4 985.1	10 018.9	9 310.2
Цэвэр, бохир усны зардал	536.0	520.5	727.3	737.9
Байрны түрээс	25.7	21.8	89.6	48.8
Хангамж, бараа материалын зардал	1 014.3	1 635.6	2 992.1	2 865.4
Нормативт зардал	4 336.9	2 436.2	4 952.4	4 164.3
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	142.6	9.6	158.8	143.8
Хоолны зардал	4 107.0	2 403.7	4 675.9	3 959.2
Нормын хувцас, зөөлөн эдлэл авах зардал	87.3	23.0	117.7	61.3
Эд хогшил, урсгал засварын зардал	359.3	147.2	530.3	334.3
Томилолт, зочны зардал	-	97.5	267.8	130.5
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	1 159.5	3 072.0	2 504.4
Бараа үйлчилгээний бусад зардал	10 475.7	2 552.1	5 176.6	3 707.5
Бараа үйлчилгээний бусад зардал	10 475.7	2 508.9	4 946.6	3 536.4
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	43.2	230.0	171.1
ТАТААС	144.8	450.3	896.4	2 319.5
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	144.8	247.0	144.9	132.2
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	-	203.3	751.6	2 187.3
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30 428.2	19 331.9	21 882.9	23 183.1
Засгийн газрын урсгал шилжүүлэг	11 877.2	537.7	558.7	534.9
Бусад урсгал шилжүүлгүүд	18 551.0	18 794.2	21 324.2	22 648.2
Нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмж	-	133.0	83.7	90.0
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	18 551.0	15 429.3	17 824.7	17 739.9
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	75.2	66.7	109.8
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	2 655.8	1 327.5	933.3
Ээлжийн амралтаар нутаг явах унааны	-	-	0.6	-
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	238.1	1 361.3	958.8
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	194.1	467.4	2 706.4
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	68.7	192.2	109.9

## Хавсралт 6-гийн үргэлжлэл

Зарлагын төрөл	2014 I	2015 I	2016 I	2017 <sup>1</sup> I
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	14 876.0	1 888.0	9 305.8	188.4
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-	-	-	82.9
Эргэж төлөгдөх цэвэр зээл	-	-	-	82.9

## 6.2 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН АЛДАГДЛЫН САНХҮҮЖИЛТ, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар

Эх үүсвэр	2014 I	2015 I	2016 I	2017 <sup>1</sup> I
	сая төгрөг			
<b>АЛДАГДЛЫН САНХҮҮЖИЛТ, ЭХ ҮҮСВЭРЭЭР</b>	<b>- 36 553.1</b>	<b>- 39 311.6</b>	<b>-14 570.0</b>	<b>-65 332.4</b>
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	- 36 553.1	- 39 311.6	-14 626.3	-65 332.4
Засгийн газрын зээл	-	-	56.3	-

<sup>1</sup>Урьдчилсан гүйцэтгэл

## 7.1 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, бүс, аймаг, нийслэлээр, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар

Аймаг, нийслэл	Нийт орлого		Орлого		Улсын төсвөөс олгож байгаа санхүүгийн дэмжлэг		Тусгай зориулалтын шилжүүлэг		Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн орлогын шилжүүлэг	
	2016 I	2017 <sup>1</sup> I	2016 I	2017 <sup>1</sup> I	2016 I	2017 <sup>1</sup> I	2016 I	2017 <sup>1</sup> I	2016 I	2017 <sup>1</sup> I
	сая төгрөг									
<b>ДҮН</b>	<b>139 544.3</b>	<b>177 574.9</b>	<b>38 780.2</b>	<b>61 846.7</b>	<b>17 232.6</b>	<b>16 154.2</b>	<b>83 531.5</b>	<b>96 872.9</b>	-	<b>2 701.1</b>
<b>Баруун бүс</b>	<b>22 475.4</b>	<b>25 096.6</b>	<b>1 142.9</b>	<b>896.6</b>	<b>5 633.4</b>	<b>5 704.3</b>	<b>15 699.1</b>	<b>18 035.7</b>	-	<b>460.0</b>
Баян-Өлгий	5 315.8	6 158.3	320.1	41.6	1 200.9	1 255.4	3 794.9	4 771.7	-	89.6
Говь-Алтай	4 086.8	4 950.0	303.0	353.0	1 059.0	1 000.9	2 724.7	3 498.7	-	97.4
Завхан	4 084.1	4 636.5	21.3	324.2	1 161.5	1 146.0	2 901.2	3 077.4	-	89.0
Увс	4 450.1	4 890.9	9.8	129.8	1 300.0	1 356.0	3 140.3	3 316.8	-	88.3
Ховд	4 538.6	4 460.9	488.7	48.0	912.0	946.0	3 137.9	3 371.1	-	95.7
<b>Хангайн бүс</b>	<b>28 009.8</b>	<b>35 730.6</b>	<b>3 029.1</b>	<b>7 722.2</b>	<b>5 968.9</b>	<b>6 409.5</b>	<b>19 011.8</b>	<b>21 000.5</b>	-	<b>598.4</b>
Архангай	4 944.2	5 278.6	552.5	665.3	1 331.0	1 454.1	3 060.7	3 060.8	-	98.4
Баянхонгор	4 446.5	5 371.7	27.1	477.6	1 376.3	1 357.8	3 043.1	3 431.3	-	105.1
Булган	2 695.2	4 807.0	321.7	1 623.6	-	-	2 373.5	3 105.0	-	78.4
Орхон	4 021.1	6 628.9	1 435.0	3 844.2	-	-	2 586.0	2 693.4	-	91.3
Өвөрхангай	4 935.4	5 977.5	58.4	348.9	1 423.7	1 398.1	3 453.3	4 121.0	-	109.5
Хөвсгөл	6 967.5	7 667.0	634.3	762.6	1 838.0	2 199.6	4 495.3	4 589.1	-	115.7
<b>Төвийн бүс</b>	<b>24 703.0</b>	<b>29 788.0</b>	<b>4 576.2</b>	<b>8 400.0</b>	<b>3 379.0</b>	<b>2 078.5</b>	<b>16 747.8</b>	<b>18 732.0</b>	-	<b>577.6</b>
Говьсүмбэр	1 197.0	1 070.6	559.8	346.2	4.3	-	632.9	676.4	-	48.1
Дархан-Уул	4 704.6	4 672.5	991.3	1 588.9	1 000.0	-	2 713.3	2 999.4	-	84.2
Дорноговь	3 243.0	3 728.7	950.9	924.4	-	-	2 292.1	2 715.7	-	88.5
Дундговь	2 806.4	3 399.9	243.4	407.7	700.0	700.7	1 863.0	2 214.4	-	77.2
Өмнөговь	2 894.2	6 304.4	591.8	3 696.6	-	-	2 302.4	2 512.7	-	95.0
Сэлэнгэ	4 686.1	5 821.6	710.9	1 333.1	455.3	450.0	3 519.9	3 944.2	-	94.4
Төв	5 171.6	4 790.2	528.1	103.0	1 219.4	927.8	3 424.2	3 669.2	-	90.2
<b>Зүүн бүс</b>	<b>11 643.1</b>	<b>13 356.1</b>	<b>1 969.7</b>	<b>2 086.5</b>	<b>2 251.2</b>	<b>1 961.9</b>	<b>7 422.2</b>	<b>9 040.2</b>	-	<b>267.5</b>
Дорнод	3 853.0	4 727.4	992.5	1 152.1	500.0	306.0	2 360.5	3 174.2	-	95.1
Сүхбаатар	3 585.9	3 695.4	511.6	396.0	742.2	622.8	2 332.1	2 594.0	-	82.6
Хэнтий	4 204.2	4 933.3	465.6	538.3	1 009.0	1 033.1	2 729.5	3 272.0	-	89.9
<b>Улаанбаатар</b>	<b>52 713.1</b>	<b>73 603.5</b>	<b>28 062.3</b>	<b>42 741.4</b>	-	-	<b>24 650.7</b>	<b>30 064.5</b>	-	<b>797.6</b>

<sup>1</sup>Урьдчилсан гүйцэтгэл



## Хавсралт 7-гийн үргэлжлэл

## 7.2 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА, бүс, аймаг, нийслэлээр, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар

Аймаг, нийслэл	Нийт зарлага		Орон нутгийн төсвийн зарлага	
	2016 I	2017 <sup>1</sup> I	2016 I	2017 <sup>1</sup> I
<b>ДҮН</b>	<b>124 974.3</b>	<b>112 242.5</b>	<b>124 974.3</b>	<b>112 242.5</b>
<b>Баруун бүс</b>	<b>19 549.5</b>	<b>18 046.3</b>	<b>19 549.5</b>	<b>18 046.3</b>
Баян-Өлгий	4 555.5	2 844.4	4 555.5	2 844.4
Говь-Алтай	3 292.4	3 507.9	3 292.4	3 507.9
Завхан	3 855.8	3 680.1	3 855.8	3 680.1
Увс	3 951.1	3 834.4	3 951.1	3 834.4
Ховд	3 894.8	4 179.5	3 894.8	4 179.5
<b>Хангайн бүс</b>	<b>25 186.9</b>	<b>24 463.6</b>	<b>25 186.9</b>	<b>24 463.6</b>
Архангай	3 538.7	3 293.2	3 538.7	3 293.2
Баянхонгор	4 010.5	3 829.0	4 010.5	3 829.0
Булган	3 198.9	3 490.0	3 198.9	3 490.0
Орхон	3 937.8	3 900.9	3 937.8	3 900.9
Өвөрхангай	4 369.9	4 694.2	4 369.9	4 694.2
Хөвсгөл	6 131.1	5 256.3	6 131.1	5 256.3
<b>Төвийн бүс</b>	<b>23 720.0</b>	<b>21 751.2</b>	<b>23 720.0</b>	<b>21 751.2</b>
Говьсүмбэр	832.5	915.6	832.5	915.6
Дархан-Уул	3 496.7	3 664.1	3 496.7	3 664.1
Дорноговь	3 216.5	3 074.2	3 216.5	3 074.2
Дундговь	2 121.6	2 508.2	2 121.6	2 508.2
Өмнөговь	5 146.4	3 058.1	5 146.4	3 058.1
Сэлэнгэ	4 402.8	4 066.0	4 402.8	4 066.0
Төв	4 503.4	4 465.1	4 503.4	4 465.1
<b>Зүүн бүс</b>	<b>10 199.4</b>	<b>9 156.8</b>	<b>10 199.4</b>	<b>9 156.8</b>
Дорнод	3 255.7	3 918.8	3 255.7	3 918.8
Сүхбаатар	3 183.6	1 100.7	3 183.6	1 100.7
Хэнтий	3 760.1	4 137.4	3 760.1	4 137.4
<b>Улаанбаатар</b>	<b>46 318.5</b>	<b>38 824.5</b>	<b>46 318.5</b>	<b>38 824.5</b>

<sup>1</sup>Урьдчилсан гүйцэтгэл

## УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар

	2014 I		2015 I		2016 I		2017 <sup>1</sup> I	
	Дүн сая төгрөг	дүнд эзлэх хувь	Дүн сая төгрөг	дүнд эзлэх хувь	Дүн сая төгрөг	дүнд эзлэх хувь	Дүн сая төгрөг	дүнд эзлэх хувь
<b>Нийт орлого, тусламжийн хэмжээ</b>	<b>353 776.6</b>	<b>100.0</b>	<b>353 562.1</b>	<b>100.0</b>	<b>335 244.5</b>	<b>100.0</b>	<b>483 455.7</b>	<b>100.0</b>
Ирээдүйн өв сан	-	-	-	-	-	-	42 899.0	8.9
Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн хэмжээ	353 776.6	100.0	353 562.1	100.0	335 244.5	100.0	440 556.7	91.1
Татварын орлого	300 685.7	85.0	317 975.9	89.9	300 451.1	89.6	360 895.6	74.6
Орлогын албан татвар	53 069.2	15.0	49 946.5	14.1	37 375.9	11.1	74 061.6	15.3
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	20 154.5	5.7	25 272.1	7.1	15 182.6	4.5	37 094.5	7.7
Хувь хүний орлогын албан татвар	32 490.0	9.2	24 567.9	6.9	22 137.5	6.6	36 968.2	7.6
Нийгмийн даатгалын орлого	62 134.5	17.6	70 142.4	19.8	86 698.2	25.9	76 967.9	15.9
Хөрөнгийн албан татвар	1 808.4	0.5	1 701.1	0.5	3 449.3	1.0	5 134.2	1.1
Нэмэгдсэн өртгийн албан татвар	100 195.8	28.3	63 723.3	18.0	76 890.2	22.9	88 856.9	18.4
Онцгой албан татвар	33 138.6	9.4	29 725.8	8.4	49 092.8	14.6	38 270.2	7.9
Тусгай зориулалтын орлого	635.9	0.2	1 083.9	0.3	674.5	0.2	897.3	0.2
Гадаад үйл ажиллагааны орлого	24 962.3	7.1	14 576.8	4.1	19 199.2	5.7	29 757.7	6.2
Бусад татвар, төлбөр, хураамж	24 740.9	7.0	87 076.2	24.6	27 071.1	8.1	46 949.8	9.7
Татварын бус орлого	53 091.0	15.0	35 586.2	10.1	34 793.3	10.4	79 661.1	16.5
Нийтлэг татварын бус орлого	52 982.2	15.0	35 502.8	10.0	34 629.2	10.3	73 574.9	15.2
Хөрөнгийн орлого	108.8	0.0	83.4	0.0	56.3	0.0	72.0	0.0
Тусламжийн орлого	-	-	-	-	107.8	0.0	6 014.2	1.2
<b>Нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ</b>	<b>413 116.9</b>	<b>100.0</b>	<b>366 356.5</b>	<b>100.0</b>	<b>415 004.0</b>	<b>100.0</b>	<b>465 881.6</b>	<b>100.0</b>
Нийт зарлага	428 345.9	103.7	386 545.6	105.5	415 004.0	100.0	463 829.2	99.6
Урсгал зардал	361 958.2	87.6	316 126.6	86.3	397 682.8	95.8	414 718.3	89.0
Бараа, ажил үйлчилгээний зардал	158 016.5	38.2	144 904.0	39.6	189 291.0	45.6	186 199.0	40.0
Хүү	25 272.8	6.1	30 718.6	8.4	30 981.9	7.5	62 333.7	13.4
Татаас	24 196.0	5.9	1 539.0	0.4	1 550.5	0.4	2 964.8	0.6
Урсгал шилжүүлэг	154 473.0	37.4	138 964.9	37.9	175 859.4	42.4	163 220.7	35.0
Засгийн газрын урсгал шилжүүлэг	58 177.6	14.1	537.7	0.1	2 473.1	0.6	718.7	0.2
Бусад урсгал шилжүүлэг	96 295.4	23.3	138 427.2	37.8	173 386.3	41.8	162 502.0	34.9
Хөрөнгийн зардал	66 387.7	16.1	70 419.0	19.2	17 321.2	4.2	49 110.9	10.5
Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	-15 229.0	-3.7	-20 189.1	-5.5	-	-	2 052.4	0.4
Эргэж төлөгдөх цэвэр зээл	-15 984.0	-3.9	-20 741.8	-5.7	-	-	82.9	0.0
Гадаадын санхүүгийн зах зээлээс санхүүжих	755.0	0.2	-	-	-	-	-	-
Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	-	-	552.7	-	-	-	1 969.5	0.4

<sup>1</sup>Урьдчилсан гүйцэтгэл

**Аргачлалын тайлбар****Хөдөлмөр****Ажиллах хүч**

Ажилгүйчүүд: Тухайн хугацаанд ажилгүй байсан, ажил хийхэд бэлэн, ажил идэвхтэй хайж байгаа хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай иргэдийг ойлгоно.

Ажилгүйдлийн түвшин: Эдийн засгийн идэвхтэй хүн амд ажилгүйчүүдийн эзлэх хувийн жингээр тодорхойлно.

Ажиллагчид: Цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд сүүлийн 7 хоногт нэгээс дээш цагаар оролцсон иргэдийг ойлгоно. Ажиллах хүчний оролцооны түвшин: Хөдөлмөрийн насны хүн амд эдийн засгийн идэвхтэй хүн амын эзлэх хувийн жингээр тодорхойлогдоно.

Хөдөлмөрийн нас: “Хөдөлмөрийн тухай” Монгол Улсын хуульд заасны дагуу 15-59 насны хүн амыг хамруулна (Хөдөлмөрийн тухай хуулийн 40.1.3, 109.2 дахь заалт).

Хөдөлмөр эрхлэлтийн түвшин: Хөдөлмөрийн насны хүн амд ажиллагчдын эзлэх хувийн жингээр тодорхойлогдоно.

Эдийн засгийн идэвхгүй хүн ам: Эдийн засгийн идэвхтэй хүн амд хамаарагдахгүй хөдөлмөрийн насны нийт хүн ам, хөдөлмөрийн насанд хүрээгүй болон хөдөлмөрийн наснаас дээш насны хүн амыг хамруулна.

Эдийн засгийн идэвхтэй хүн ам (ажиллах хүч): Тухайн цаг хугацаанд бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхэд ажиллах хүчээ нийлүүлж байгаа ажиллагч, нийлүүлэхэд бэлэн байгаа ажилгүй иргэдийг хамруулна.

**Бүртгэлтэй ажилгүй иргэн**

Бүртгэлтэй ажилгүй иргэд: Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил

идэвхтэй хайж байгаа хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, хөдөлмөрийн төв бирж, хөдөлмөрийн хувийн биржид бүртгүүлсэн ажилгүй иргэдийг хамруулна.

**Өрхийн орлого, зарлага**

Нэг өрхөд ногдох сарын дундаж орлого, зарлага: Улирлын турш уг судалгаанд хамрагдсан өрхийн сарын дунджаар тооцно.

Өрхийн мөнгөн зарлага: Хүнсний бүтээгдэхүүний; хүнсний бус бараа, үйлчилгээний; бусдад өгсөн бэлэг, тусламж болон бусад зарлага багтана. Өрхийн мөнгөн орлого: Цалин хөлс; тэтгэвэр, тэтгэмж, нөхөн олговор; хувийн аж ахуйн орлого болон бусад орлогоос бүрдэнэ.

Өрхийн нийт зарлага: Өрхийн мөнгөн зарлага дээр өрхийн өөрийн аж ахуйгаас бэлтгэж хэрэглэсэн болон бусдаас үнэгүй авч хэрэглэсэн зүйлсийг тухайн орон нутгийн зах зээлийн дундаж үнээр үнэлсэн мөнгөн дүнг нэмж тодорхойлно.

Өрхийн нийт орлого: Өрхийн мөнгөн орлого дээр өрхийн өөрийн аж ахуйгаас бэлтгэж хэрэглэсэн болон бусдаас үнэгүй авч хэрэглэсэн зүйлсийг тухайн орон нутгийн зах зээлийн дундаж үнээр үнэлсэн мөнгөн дүнг нэмж тодорхойлно.

Хувийн аж ахуйн орлого: Мал аж ахуйн болон газар тариалангийн үйлдвэрлэлийн орлого; хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, үйлчилгээний орлогыг оруулна.

**Нийгмийн даатгал, халамж**

Даатгуулагч: Нийгмийн даатгалын тухай хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд нийгмийн даатгалын шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг ойлгоно.

Нийгмийн даатгал: Иргэн болон төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын сан бүрдүүлэх, даатгуулагч өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдах, өвчлөх, ажилгүй

болоход өөрт нь, тэрчлэн даатгуулагч нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр өгөх агуулга бүхий нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм.

Нийгмийн даатгалын төрлүүд: Тэтгэврийн, тэтгэмжийн, эрүүл мэндийн, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний, ажилгүйдлийн даатгал гэсэн төрлөөс бүрдэнэ. Нийгмийн даатгалын сан: Энэ нь ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах болон нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдэнэ.

Нийгмийн халамж: Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай хүнд хуульд заасан тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж олгох, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн болон төрөлжсөн асрамжийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг ойлгоно.

Тэтгэвэр: Даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөгжлийн бэрхшээлтэй болоход хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, эсхүл өндөр насны тэтгэвэр авах насанд хүртэл, нас барахад нь түүний гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд /хүүхэд 16 нас, сургуульд суралцаж байгаа бол 19 нас хүртэл /-ийн нийгмийн баталгааг хангах зорилгоор нийгмийн даатгалын сангаас олгох мөнгөн хөрөнгийг ойлгоно.

Тэтгэмж: Хөдөлмөрийн чадвараа түр алдах, жирэмслэх, амаржих, нас барах тохиолдолд даатгуулагчид нийгмийн даатгалын сангаас нэг удаа олгох мөнгөн хөрөнгийг ойлгоно.

### Эрүүл мэнд

Амьд төрөлт: Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан, эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байгааг (хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүй) хамруулна.

Нялхсын эндэгдлийн түвшин: Тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин: Тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Халдварт өвчний өвчлөлийн 10000 хүнд ногдох түвшин: Тайлант хугацаанд амбулаторийн үзлэгээр шинээр бүртгэгдсэн нийт халдварт өвчний тохиолдлын тоог тухайн хугацааны дундаж хүн амын тоонд харьцуулж тооцно.

Эндсэн эх: Жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөлт болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндэснийг хамруулна.

### Байгаль орчин

Агаарын бохирдол: Агаар мандалд нэг буюу хэд хэдэн химийн бодис дагнасан буюу хавсарсан байдлаар хүн, амьтан, ургамлын аймгийн амьдрал, ахуйн нөхцөл, үйл ажиллагаанд сөрөг нөлөөлөл үзүүлж, стандартаар тогтоосон хүлцэх хэм хэмжээнээс давсан агаар дахь бохирдуулах бодис тодорхой хугацаагаар байхыг ойлгоно.

Аюулт үзэгдэл: Хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт болох, гал түймэр, хүн, мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин гарах, хортон мэрэгчид тархах зэргийг ойлгоно.

Гамшиг: Аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн улмаас олон хүний эрүүл мэнд, амь нас хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд улс, орон нутгийн дотоод нөөц боломжоос давсан хохирол учрахыг хэлнэ.

Зөвшөөрөгдөх түвшин: Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх агаар дахь физикийн бохирдуулагчийн зөвшөөрөгдөх түвшинг ойлгоно.

Хүлцэх агууламж: Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх агаар дахь химийн бохирдуулагчийн зөвшөөрөгдөх хэмжээг ойлгоно.

### Гэмт хэрэг

Гэмт хэрэг: Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан, нийгэмд аюултай, гэм буруутай үйлдэл, эс үйлдэхгүйг хэлнэ.

18, түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэрэг: Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоог 18, түүнээс дээш насны хүн амын дундаж тоонд харьцуулж тооцно.

Гэмт хэргийн хохирогч: Гэмт хэргийн улмаас нэр төр, алдар хүнд, санаа сэтгэл, бие эрхтэн, эд хөрөнгийн талаар хохирол хүлээсэн этгээдийг ойлгоно /МУ-ын “Эрүүгийн байцаан шийтгэх” хуулийн 42.1 дэх заалт/.

Учирсан хохирол: Гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эдийн болон эдийн бус хөрөнгийн эрхэд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно.

Нөхөн төлбөр: Хохирлын нөхөн төлүүлэлт нь хүний эрх, эрх чөлөөний хир хэмжээ, учруулсан хор уршигт дүйцэхүйц байх ёстой бөгөөд хохирогчийн эрх, эрх чөлөө, хувийн байдал, гэр бүл, эд хөрөнгө, хөдөлмөр эрхлэлт, сургууль, боловсролын түвшинг аль болох өмнө нь байсан хэмжээнд сэргээн бүрдүүлэхийг ойлгоно.

Сэжигтэн: МУ-ын “Эрүүгийн байцаан шийтгэх” хуулийн 35.1-д заасны дагуу хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч энэ хуулиар тогтоосон үндэслэл, журмын дагуу эрүүгийн хэрэг үүсгэж, дор дурдсан этгээдийг сэжигтнээр тооцож, үндэслэл бүхий тогтоол гаргана:

- уг этгээдийг гэмт хэрэг үйлдэж байх үед буюу үйлдсэн дор нь барьсан;
- гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хохирогч буюу харсан хүн шууд заасан;
- уг этгээдийн бие, хувцас, эд зүйл, орон байранд гэмт хэргийн ул мөр тодорхой илэрч олдсон;
- уг этгээд хэргээ илчлэн ирсэн;
- гэмт хэрэгт сэрдэгдэх үндэслэл бүхий бусад баримт байгаа бол.

Яллагдагч: МУ-ын “Эрүүгийн байцаан шийтгэх” хуулийн 36.1-д заасны дагуу энэ хуулиар тогтоосон журмын дагуу хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч тогтоол үйлдэж, ял сонгосон этгээдийг ойлгоно.

### Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)

Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ): Тухайн нутаг дэвсгэрийн хүрээнд тайлант хугацаанд дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн шинээр бүтээсэн нийт нэмэгдэл өртгийн хэмжээ юм. ДНБ-ийг дараах 3 аргаар тооцдог.

**Үйлдвэрлэлийн арга:** Нийт үйлдвэрлэлээс завсрын хэрэглээг хасч, нэмэгдэл өртгийн нийлбэр дүнгээр тооцох аргыг хэлнэ.

**Эцсийн ашиглалтын арга:** Эцсийн хэрэглээ, хуримтлал, цэвэр экспортын нийлбэрээр тооцох аргыг хэлнэ.

**Орлогын арга:** Хөдөлмөрийн хөлс, үндсэн хөрөнгийн хэрэглээ, үйлдвэрлэлийн татвар, ашиг, түүнтэй адилтгах орлого зэрэг орлогын үзүүлэлтийн нийлбэрээр тооцох аргыг хэлнэ.

ДНБ-ий улирлын тооцоо: Тухайн салбарын жилийн үйл ажиллагааны улирлын өөрчлөлтийг харуулж чадах богино хугацааны шалгуур үзүүлэлтийг ашиглан, тэдгээрийн өсөлт, бууралтын хандлагаар салбарын нэмэгдэл өртгийг тооцно.

Үйлдвэрлэлийн арга: Улирлын нэмэгдэл өртгийн хэмжээг тооцохдоо улирлын үндсэн үзүүлэлтийн хэмжээг VI-харьцаа буюу өмнөх оны улирлын нэмэгдэл өртөг болон салбарын үндсэн үзүүлэлтийн харьцаагаар үржүүлж тооцно.

$$VA_t = I_t * \left( \frac{VA_{t-1}}{I_{t-1}} \right) = VA_{t-1} * EI_t$$

$\frac{VA}{I}$  - VI харьцаа буюу нэмэгдэл өртөг, үндсэн үзүүлэлтийн харьцаа

VA - Нэмэгдэл өртгийн хэмжээ

$EI_t = \frac{I_t}{I_{t-1}}$  - Экстраполятор буюу салбарын үндсэн үзүүлэлтийн өсөлт

t (t-1) - Тайлант он (тайлант оны өмнөх жил)

## Мөнгө, зээл, үнэт цаас

Бага мөнгө /M1/: Хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө болон төгрөгийн харилцах дансан дахь мөнгөний нийлбэрээр тодорхойлно.

Хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө: Төв банкнаас гүйлгээнд гаргасан цаасан болон зоосон мөнгөнөөс банкуудын эзэмшиж буй цаасан болон зоосон мөнгийг хасна.

Бараг мөнгө: Төгрөгийн болон гадаад валютын хадгаламж, валютын харилцах, цэвэршүүлсэн алтны харилцах, хадгаламжийн сертификатын нийлбэрээр тодорхойлно.

Брокерийн үйл ажиллагаа: Үнэт цаасны зах зээлд бусдын нэрийн өмнөөс үнэт цаасыг зуучлан худалдах, худалдан авах ажиллагааг ойлгоно.

Бүртгэлтэй компани: Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй, хувьцааны арилжааг идэвхтэй хийдэг хувьцаат компаний тоог хамруулна.

Валютын харилцах: Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын валютын харилцах дансны үлдэгдлийн нийлбэрээр тодорхойлно.

Гадаад валютын албан нөөц: Монголбанкны эзэмшилд байгаа, захиран зарцуулахад бэлэн, чөлөөтэй хөрвөдөг гадаад валютыг хамруулна.

Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө: Хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө болон банкны касс дахь бэлэн мөнгөний нийлбэрээр тооцно.

Дилерийн үйл ажиллагаа: Үнэт цаасны зах зээлд ашиг олох зорилгоор үнэт цаасыг өөрийн хөрөнгөөр худалдан авах, худалдах, арилжих ажиллагааг ойлгоно.

Зах зээлийн үнэлгээ: Хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компаний нийтэд гаргасан үнэт цаасны тоо, тухайн өдрийн үнэт цаасны арилжааны хаалтын ханшны үржвэрээр тодорхойлно.

Мөнгөний нийлүүлэлт /M2/: Хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө, төгрөгийн болон валютын харилцах, хадгаламж, цэвэршүүлсэн алтны харилцах, хадгаламжийн сертификатын

нийлбэрээр тодорхойлно. Өөрөөр хэлбэл, бага мөнгө болон бараг мөнгөний нийлбэрээр тодорхойлно. Зөвхөн цэвэршүүлсэн алтны харилцах дансны үлдэгдлийг хамруулах бөгөөд бусад үнэт металлын харилцах дансны үлдэгдлийг хамруулахгүй.

Нөөц мөнгө /M0/: Банкны касс байгаа бэлэн мөнгө, хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө болон Монголбанк дахь банкуудын төгрөг, валютын харилцах, валютын хадгаламжийн нийлбэрээр тодорхойлно.

Өрийн бичиг (бонд): Тодорхой хугацааны дараа үндсэн төлбөр болон хүүг мөнгөн, эсхүл тодорхой эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн хэлбэрээр эргүүлэн төлөх үүргийг гэрчилсэн үнэт цаасыг ойлгоно.

ТОП 20 индекс: Үнэт цаасны үнийн ерөнхий өөрчлөлтийг илэрхийлэх бөгөөд Хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компаниудын үнэт цаасны зах зээлийн үнэлгээ, үнэт цаасны өсөлт, бууралтаар үнэт цаасны зах зээлийн ерөнхий чиг хандлагыг тодорхойлно. Индексийг дараах томъёогоор тооцно.

$$I = \frac{P}{C} * 100$$

$I$  - Тухайн өдрийн индекс

$P$  - Тухайн өдрийн зах зээлийн үнэлгээ

$C$  - Зах зээлийн суурь үнэлгээ

Төгрөгийн харилцах дансан дахь мөнгө: Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын төгрөгийн харилцах дансны үлдэгдлийн нийлбэрээр тодорхойлно.

Төгрөг болон валютын хадгаламж: Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын төгрөг, валютын хадгаламжийн үлдэгдлийн нийлбэрээр тодорхойлно.

Үнэт цаас: Засгийн газар болон бусад эрх бүхий этгээдээс гаргасан өрийн бичиг /бонд/, компаний бүх төрлийн хувьцаа, компаний гаргасан, эсхүл гаргахаар санал болгож буй хувьцааг худалдах, худалдан авах эрхийн бичиг (опцион), хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа, түүнчлэн Санхүүгийн зохицуулах хорооноос Монгол Улсын "Үнэт цаасны зах зээлийн тухай" хуульд нийцүүлэн үнэт цаас гэж тодорхойлсон баримтыг ойлгоно.

Хадгаламжийн сертификат: Арилжааны банкнаас гаргасан иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшиж буй хадгаламжийн сертификатаар тодорхойлно.

Хувьцаа: Компанид хөрөнгө оруулж, түүнийг үндэслэн хувь нийлүүлэгчдийн хуралд оролцож санал өгөх, ногдол ашиг авах, компанийг татан буулгасны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдан борлуулснаас олсон орлогоос хувь хүртэх болон хуулиар тогтоосон бусад эрхийг гэрчилсэн үнэт цаасыг ойлгоно.

Хугацаа хэтэрсэн зээл: Зээл, хүүгийн хугацаа 90 хүртэл хоног хэтэрсэн зээлийг хамруулна.

Хэвийн зээл: Төлөвлөгдсөн хугацаанд байгаа зээл, түүний хүүг ойлгоно.

Хэлцэл: Үнэт цаасыг худалдах захиалгын үнийн саналыг худалдан авах иргэд, аж ахуйн нэгж, байгууллага зөвшөөрснөөр үнэт цаас арилжаалахыг ойлгоно.

Чанаргүй зээл: Хэвийн бус, эргэлзээтэй, муу зээл буюу зээл, хүүгийн хугацаа 91-ээс дээш хоног хэтэрсэн зээлийг хамруулна.

#### Улсын нэгдсэн төсөв

Монгол Улсын нэгдсэн төсөв: Улсын төсөв, орон нутгийн төсөв, хүний хөгжил сангийн төсөв болон нийгмийн даатгалын сангийн төсвөөс бүрдэнэ.

Тэнцвэржүүлсэн орлого: Татварын болон татварын бус орлогоос бүрдэнэ.

Орон нутгийн төсөв: Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлан аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга бүрдүүлж, зарцуулах төсвийг хэлнэ. Татварын орлого: Орлогын албан татвар, нийгмийн даатгалын орлого, хөрөнгийн албан татвар, нэмэгдэл өртгийн албан татвар, онцгой албан татвар, тусгай зориулалтын орлого, гадаад үйл ажиллагааны орлого, бусад татвар, төлбөр, хураамжаас бүрдэнэ.

Татварын бус орлого: Нийтлэг татварын бус орлого, хөрөнгийн орлого, тусламжийн орлого, улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлгээс бүрдэнэ.

Төсвийн зарлагын ангилал: Урсгал зардал, хөрөнгийн зардал, эргэн төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл;

Төсвийн орлого: Тогтворжуулалтын сангийн болон тэнцвэржүүлсэн орлогоос бүрдэнэ.

Улсын төсөв: Улсын Их Хурал (УИХ)-аас батлан Засгийн газар бүрдүүлж зарцуулах төсвийг хэлнэ.

Урсгал зардал: Бараа, ажил, үйлчилгээний зардал, зээлийн үйлчилгээний төлбөр, татаас ба урсгал шилжүүлгээс бүрдэнэ.

#### Гадаад худалдаа

Гадаад худалдааны барааны нийт эргэлт: Экспорт, импортын нийлбэрээр тодорхойлно. Гадаад худалдааны тэнцэл: Нийт экспортоос импортыг хассан зөрүүгээр тэнцлийг тодорхойлно. Тэнцэл (-) тэмдэгтэй бол алдагдалтай, (+) тэмдэгтэй бол ашигтай гэж үзнэ. Импорт: Улсын материаллаг нөөцийг нэмэгдүүлэн, хилийн чанадаас эдийн засгийн нутаг дэвсгэрт оруулж байгаа барааг тооцно. Нийт импортод гадаадын барааны шууд импорт, дотоодын барааны реимпорт багтана.

Экспорт: Улсын материаллаг нөөцийг хорогдуулан, эдийн засгийн нутаг дэвсгэрээс хилийн чанадад гаргаж байгаа барааг тооцно. Нийт экспортод дотоодын барааны шууд экспорт, гадаадын барааны реэкспорт багтана. Реимпорт: Өмнө нь экспортод бүртгэгдсэн дотоодын барааны импортыг ойлгоно. Реэкспорт: өмнө нь импортод бүртгэгдсэн гадаадын барааны экспортыг ойлгоно.

Эх орны үйлдвэрлэлийн бараа: Тухайн улс оронд импортоор оруулж, дахин боловсруулалт хийсэн, үндсэн чанар буюу техникийн шинжийг өөрчилсөн гадаад гаралтай барааг оруулна.

## Үнэ

Инфляци: Үнэ өсч тэр хэмжээгээр мөнгөний ханш буурахыг хэлнэ. Инфляцийн түвшинг тооцоходоо дараах томъёог ашиглана. Үүнд:

$$\text{Инфляцийн түвшин} = \frac{I_t - I_0}{I_0} * 100$$

$I_t$  – Тайлант үеийн үнийн индекс  
 $I_0$  – Суурь үеийн үнийн индекс

Хэрэглээний бараа, үйлчилгээний жин: Өрхийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нийт зардалд тухайн бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувийн жинг хэлнэ.

Хэрэглээний сагс: Дундаж зарлагатай өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хэрэглээний үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний нэр төрлийн жагсаалт юм. Сагсанд сонгогдсон бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг тооцоход бараа, үйлчилгээний тоо хэмжээ, төрөл, чанар зэргийг тогтмолоор авч үздэг.

Хэрэглээний үнийн индекс (ХҮИ): Хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна. ХҮИ-ийн тооцоонд хэрэглээний сагс, хэрэглээний жин гэсэн хоёр үзүүлэлтийг ашиглан, Ласпейресийн үнийн индексийн томъёогоор тооцож байна. Үүнд:

$$I_p^t = \frac{\sum_{i=1}^n (p_i^t * q_0^i)}{\sum_{i=1}^n (p_0^i * q_0^i)}$$

$I_p^t$  - t тайлант үеийн Ласпейресийн үнийн индекс  
 t – Тайлант үе  
 0 – Суурь үе  
 $p_i^t$  – i барааны тайлант үеийн үнэ  
 $p_0^i$  – i барааны суурь үеийн үнэ  
 $q_0^i$  - i барааны суурь үеийн худалдан авсан тоо

Өрхийн нийгэм, эдийн засгийн 2010 оны судалгааны үр дүнгээр хэрэглээний сагсан дахь нэр төрлийг 2011 онд 329 болгон нэмэгдүүлж, (аймгуудад 214 нэр төрөл), хэрэглээний зардлын жинг шинэчилж, 2012 оны 1 дүгээр сараас эхлэн хэрэглээний үнийн улсын индексийг тооцоход ашиглаж байна. Мөн хөдөө аж ахуйн гол нэр төрлийн зарим бүтээгдэхүүний зах зээлийн үнийн судалгааг сар бүр сум, дүүрэг, аймаг, нийслэлийн үнэ цуглуулдаг нэгжүүдээс

нэгтгэн авч, сарын дундаж үнийг арифметик дунджаар, Улаанбаатар хотод борлуулагдаж буй махны дундаж үнийг хүнсний захуудын махны борлуулалтын хэмжээгээр жигнэн тооцож байна.

## Хөдөө аж ахуй

Том малын зүй бусаар хорогдол: Өвчнөөр (халдвартай, халдваргүй) болон гэнэтийн аюулаар (цас, зуд, үер, ус, гал түймэр, аянга, цахилгаан зэрэг) хорогдсон, бусад шалтгааны (малын хариулга, арчилгаа маллагаатай холбогдон гарсан) улмаас хорогдсон малыг хамруулна.

Төллөлтийн хувь: Төллөсөн хээлтэгч малын тоог оны эхний хээлтэгч малын тоонд харьцуулж тооцно.

Төл бойжилтын хувь: Бойжуулсан төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулж тооцно.

Тариалсан талбай: Хөдөө аж ахуйн ургамал тариалсан талбайг хэлэх бөгөөд тухайн хугацаанд үр суулгасан газрын нийт хэмжээгээр тодорхойлно.

## Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн: Аж ахуйн нэгжүүдийн тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл: Аж ахуйн нэгжүүдийн тайлант хугацаанд зах зээлд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ.

Үйлдвэрлэлийн биет хэмжээний индекс: Аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүнийг сар бүрийн мэдээлэлд хамруулан судалж, Ласпейресийн биет хэмжээний индексийн томъёог ашиглан тооцно. Ласпейресийн биет хэмжээний индексийн томъёо:

$$I_D = \frac{\sum (Q_t \cdot P_0)}{\sum (Q_0 \cdot P_0)} \cdot 100 = \sum \left( \frac{Q_t}{Q_0} \right) \cdot W_0 \cdot 100$$



*Qt* - Тайлант үеийн бүтээгдэхүүний биет хэмжээ

*QO* - Суурь үеийн бүтээгдэхүүний биет хэмжээ

*PO* - Суурь үеийн бүтээгдэхүүний үнэ

*WO* - Жин

Эдийн засгийн үйл ажиллагааны ангилал: НҮБ-аас гишүүн орнууддаа мөрдөхийг зөвлөмж болгосон эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны олон улсын стандарт ангилалд нийцүүлэн боловсруулсан үндэсний ангилал юм

### Дотоод худалдаа

Худалдааны нийт үйлдвэрлэл: Бөөний болон жижиглэн худалдааны байгууллагуудын худалдаж авсан бараа, бүтээгдэхүүнийг борлуулснаас орсон орлого буюу худалдааны нэмэгдэл, ажиллагчиддаа цалингийн оронд олгосон бүтээгдэхүүн, барилга, байшин, машин, тоног төхөөрөмж түрээслүүлснээс олсон орлого, үндсэн бус үйл ажиллагаа (хоёрдогч, гуравдагч салбарын үйл ажиллагааны орлого, туслах чанарын үйлдвэрлэл, үйлчилгээний орлого зэрэг)-наас орсон орлого, бусад орлого (үндсэн хөрөнгө худалдсанаас орсон орлого, ногдол ашиг, даатгалын нөхөн төлбөр, валютын ханшийн өөрчлөлтөөс олсон орлого орохгүй)-ыг хамруулна.

Худалдааны нийт борлуулалт: Тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний борлуулалтын дүн бөгөөд тайлант хугацаанд худалдааны салбарын аж ахуйн нэгжүүдийн цэвэр борлуулалтын нийлбэрээр тодорхойлно.

Цэвэр борлуулалт: Электрон худалдааны борлуулалтыг оруулсан нийт борлуулалтаас борлуулалтын буцаалт, хөнгөлөлтийг хасч тооцно.

### Тээвэр

Ачаа эргэлт: Нэг тонн ачаа нэг км-ээс дээш зайд тээвэрлэсэн тээврийг хэмждэг нэгж юм. Ачаа эргэлтийг тн.км-ээр илэрхийлнэ.

Зорчигч эргэлт: Нэг зорчигчийг нэг км-ээс дээш зайд тээвэрлэсэн тээврийг хэмждэг нэгж юм. Зорчигч эргэлтийг хүн.км-ээр илэрхийлнэ.

Тээврийн орлого: Тээврийн үйлчилгээ үзүүлсэний төлбөр болгож авч байгаа өртгийн нийлбэр юм. Өөрөөр хэлбэл тээврийн байгууллагуудын үйл ажиллагааны үр дүн буюу ачаа, зорчигч тээвэрлэлт, түүнтэй холбогдсон үйл ажиллагаанаас орсон орлого юм.

Шилжүүлсэн тонн километр: Тээврээр гүйцэтгэсэн олон төрөл, хэлбэрийн ажил, үйлчилгээг тусгай коэффициентууд ашиглан нэг нэгжид буюу тонн километр (тн.км)-т шилжүүлсэн үзүүлэлтийг ойлгоно.

### Нийтийн хоол, зочид буудал

Зоогийн газрын үйл ажиллагаа: Ресторан, кафе, баар, гуанз, захиалгат хоол хүнсээр үйлчлэх, хүргэх газруудыг хамруулна

Зочид буудлын үйл ажиллагаа: Зочид буудал, амралтын газар, хүүхдийн зуслан, түр хоноглох байруудыг хамруулна.

Нийт орлого: Үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны үйлчилгээний орлого орно.

Нийт зардал: Зочид буудал, зоогийн газрын үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдон гарсан болон үйл ажиллагааны бусад төрлийн зардал (ажиллагчдын үндсэн ба нэмэгдэл цалин, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, тээврийн зардал, зар сурталчилгаа, үндсэн хөрөнгийн элэгдэл гэх мэт)-ууд орно.

Өрөөний тоо: Тухайн үйлчилгээний газрын байшин, барилгын зочид, үйлчлүүлэгчдийг хоноход зориулсан өрөө тасалгааг хамруулна.

Суудлын тоо: Бүх зоогийн газруудын суудлын тооны нийлбэрээр тооцно.